

ХОРШООНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА (Харьцуулсан судалгаа)

Г. Билгээ, Ц. Батдорж, Ц. Болормаа,
Б. Дуламсүрэн, Д. Мягмарцэрэн, Ч. Онончимэг

Агуулга

Оршил

1. Хоршооны эрх зүйн зохицуулалт

1.1. Хоршооны тухай ойлголт, төрлүүд, эрх зүйн зохицуулалт

- 1.1.1. Хоршооны тухай ойлголт
- 1.1.2. Хоршооны төрөл
- 1.1.3. Хоршооны үйл ажиллагааны төрөл
- 1.1.4. Хоршооны эрх зүйн зохицуулалт

1.2. Олон улсын байгууллагуудаас гаргасан зохицуулалтууд

- 1.2.1. Нэгдсэн Үндэсний Байгууллагын тогтоол
- 1.2.2. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
- 1.2.3. Олон Улсын Хоршооллын Альянс

2. Хоршооны эрх зүйн зохицуулалтын талаарх бусад орны туршлага

(Бельги, Дани, Испани, ОХУ, Португал, Унгар, Филиппин, Франц, Тайланд, ХБНГУ)

2.1. Хоршооллох хөдөлгөөны хөгжил

2.2. Хоршооны тодорхойлолт, зарчим

2.3. Хоршоодын эрхлэх эдийн засгийн үйл ажиллагааны төрөл, цар хүрээ

2.4. Хоршоог бүртгэх

2.5. Хоршооны гишүүн

- 2.5.1. Хоршооны гишүүдийн тооны доод хязгаар
- 2.5.2. Хоршоонд гишүүнээр элсэх
- 2.5.3. Хөрөнгө оруулагч-гишүүн элсүүлэх тухай
- 2.5.4. Хоршооны гишүүний эрх, үүрэг

2.6. Хоршооны удирдлага

2.7. Хоршооны эд хөрөнгө ба хоршооны орлогыг хуваарилах, зарлагыг нөхөх

- 2.7.1. Хоршооны эд хөрөнгийн доод хэмжээ
- 2.7.2. Илүүдэл хөрөнгийг зарцуулах болон хуулийн дагуу заавал бүрдүүлэх нөөцийн санд хуваарилах
- 2.7.3. Нөөцийн сангийн хөрөнгийг хуваарилах
- 2.7.4. Гишүүдийн нийлүүлсэн хувь хөрөнгөөс ногдол ашиг хуваарилах

2.8. Аудит болон бусад хяналт шалгалт

2.9. Хоршоог татан буулгах

2.10. Хоршооны татварын харилцаа

Хавсралт 1. Нийгмийн хөгжилд хоршооллын гүйцэтгэх үүрэг

* * *

ОРШИЛ

НҮБ -ын Ерөнхий ассамблейн 64 -р чуулганаас 2012 оныг “Олон улсын хоршооллын жил” болгон зарласан. Өнөөдөр дэлхийн долоон тэрбум хүний гурван тэрбум нь хоршооноос ашиг хүртэж, 100 сая ажлын байрыг бий болгосон байна. Манай улсын хувьд, 1990-ээд оны үед сум нэгдэл гэж байснаа задарч, хоршооллыг байгуулсан ч энэ нь төдийлөн үр дүнтэй ажил болж чадаагүй. Харин сүүлийн жилүүдэд иргэд бизнесийн салбарт ахиухан мөнгөгүй л бол ганцаарчилсан тоглолт хийгээд үр дүнгүй гэдгийг ойлгож байгаа тул, хоршоолол байгуулах хандлага нэмэгдсэн.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад 2000 орчим хоршоо үйл ажиллагаа явуулж буй бөгөөд ирэх жилээс энэ тоо улам нэмэгдэх хандлагатай байна. Гэвч иргэдийн дунд хоршооллын жинхэнэ мөн чанарыг ухаарч хамтран хоршиж бизнес эрхлэн үр ашгийг нь хүртэхээс илүүтэй Хоршооллыг дэмжих агуулгатай төрөөс үзүүлж буй зээл, тусламж, дэмжлэгийг хүртэх сонирхол нь илүү давамгайлж байна. Ингэснээр нэг хүний эзэмшилд байдаг, хэлбэрийн төдий хоршоонууд бий болж байгаа нь хоршооллын цаашдын хөгжилд сөргөөр нөлөөлөх үндэс болж байна.

Иймээс цаашид бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд үүнийг харгалзан үзэж хоршоолох хөдөлгөөнийг зүй зохистой чиглэлээр хөгжүүлэхийн тулд “**Олон улсын хоршооны үндсэн зарчим**” болон хоршооны талаарх олон улсын чиг хандлагад нийцсэн хоршоог дэмжих чиглэл баримтлах нь зүйтэй юм.

Судалгаанд хоршооны талаарх үндсэн ойлголт, зарчим, шалгууруудыг хэрхэн тодорхойлж талаар авч үзсэн бөгөөд үүнийг тодруулах үүднээс тодорхой улс орнууд дахь хоршооны зохицуулалтуудыг жишээ болгон дэлгэрэнгүй байдлаар дурдлаа. Ингэхдээ хоршоолох хөдөлгөөн анх үүсэн бий болсон, хөгжлийн зөв голдрилоор явахад нь хангалттай хэмжээний эрх зүйн зохицуулалтуудтай учраас Европ тивийн улс орнуудын холбогдох жишээг судалгаанд сонгон авсан. Харин Япон, Солонгос, Тайланд, Филиппин, Энэтхэг зэрэг Азийн улсуудыг хуулийнх нь хүрээ, агуулга, тухайн асуудлыг хэрхэн шийдсэн зэргийг нь харгалзан онцолж сонгон авч үзсэн болно. Үүнд:

- Хоршооны тодорхойлолт, үйл ажиллагааны зорилго
- Хоршоодын эрхлэх эдийн засгийн үйл ажиллагааны төрөл, цар хүрээ
- Хоршоог бүртгэх
- Хоршооны гишүүн
- Хоршооны удирдлага
- Хоршооны эд хөрөнгө ба орлогыг хуваарилах, зарлагыг нөхөх
- Аудит болон бусад хяналт шалгалт
- Хоршоог татан буулгах

Нэгдүгээр бүлэг. **ХОРШООНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

1.1. Хоршооны тухай ойлголт, төрлүүд, эрх зүйн зохицуулалт

Сүүлийн үед хоршооны хөгжлийн асуудалд ОУ-ын байгууллага, Засгийн газрууд илүү ач холбогдол өгч, илүү анхаарах болсноор хоршооллын хөдөлгөөн нь улам өргөжиж, орлогыг шударгаар хуваарилах, ажлын байр бий болгох, ажилгүйдлийг багасгах, байгаль орчныг хамгаалахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж, хоршоо нь эдийн засгийн чиглэлтэй, өөртөө туслах байгууллага гэдэг үзэл санаа давамгайлж байна.

1.1.1. Хоршооны тухай ойлголт

Хоршооны бусад аж ахуйн нэгжээс ялгагдах гол онцлог түүний заримдаг шинж чанарт оршиж байна. Хоршоо нь нэг талаас иргэд сайн дурын үндсэн дээр эвлэлдэн байгуулж, нийгэмлэг харилцаан дээр тулгуурладаг хэсэг хүмүүсийн холбоо, нөгөө талаас нь авч үзвэл гишүүдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор ашиг орлоготой ажиллаж байж оршин тогтнож байгаа аж ахуйн нэгж юм¹⁹.

Монгол Улсын Хоршооны тухай хуулийн 3.1-т: “Эдийн засгийн болон нийгэм, соёлын **нийтлэг хэрэгцээгээ** хангах зорилгоор хэд хэдэн этгээд **сайн дураараа нэгдсэн**, ардчилсан хамтын удирдлага, хяналт бүхий дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар хамтран байгуулсан **хуулийн этгээдийг** хоршоо гэнэ” хэмээн заажээ. Эдгээр тодорхойлолтонд хоршооны үндсэн 3 онцлогийг янз бүрийн боловч ижил агуулгаар тусгасаныг харж болно. Үүнд:

- гишүүдээ дэмжих нийтлэг зорилготой;
- сайн дураар эвлэлдэн нэгдсэн;
- аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг.

Өөр ямар ч хуулийн этгээд ийм заримдаг шинжийг агуулдаггүй билээ. Хоршооны тухай тодорхойлолт нь компани, ТББ зэрэг бусад хуулийн этгээдийн тодорхойлолтоос ялгаатай бөгөөд хоршооны дараах онцлог шинжийг тусгавал зохино гэсэн байна.²⁰ **Нэг дэх нь** хоршооны хамтын зарчим бөгөөд гишүүд нь хоршооны хамтын үүсгэн байгуулагч байх бөгөөд хоршоог хамтарч санхүүжүүлнэ. Хоршоог хамтарч өмчилж, хамтдаа удирдаж, хянаж, хоршооны үйлчилгээг хамтдаа хэрэглэж, хоршооны өр төлбөр, алдагдлыг хамтарч хариуцна. **Хоёр дахь нь** хоршоо хөрөнгө оруулж, их хэмжээний ашиг олохыг эрмэлзэхээс илүү гишүүдээ дэмжиж, тэдний нийгэм, эдийн засгийн байдлыг сайжруулахад анхаарна.

1.1.2. Хоршооны төрөл

Хоршоог эрхэлж буй үйл ажиллагааных нь чиглэлээр хоёр үндсэн хэсэг болгон ангилдаг. Үүнд:

1. Үйлчлэн зуучлах чиглэлтэй,
2. Үйлдвэрлэлийн чиглэлтэй.

Үйлчлэн зуучлах хоршоо нь гишүүдийн бүтээгдхүүн, түүхий эд, барааг худалдан авч зуучлан борлуулах, гишүүдээ хэрэгцээт бараа болон шаардлагатай техник, тоног төхөөрөмж, материалаар хангах, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг, гол төлөв гишүүд нь үйлдвэрлэл эрхэлдэг, хоршоо нь тэдэнд дэмжлэг үзүүлдэгээрээ онцлогтой. Гишүүд нь бараа бүтээгдэхүүн нийлүүлэгч-худалдан авагчийн үүрэгтэй байдаг учир хоршоо гишүүдийн хоорондын харилцааг нарийн зохицуулах шаардлагатай.

Үйлдвэрлэлийн хоршоо нь өөрөө бараа бүтээгдхүүн үйлдвэрлэдэг бөгөөд гишүүд нь түүний үйл ажиллагаанд биечлэн оролцож, хоршооныхоо үйлдвэрлэлийг өргөтгөхийг илүү их сонирхдог, шаардлагатай бол гишүүд хоршооны бараа, бүтээгдхүүнийг өөрсдөө худалдан авдаг, гишүүдээ ажлын байраар хангахад илүү их анхаардгаараа үйлдвэрлэлийн хоршоодын ач холбогдол тодорхойлогдоно. Түүнчлэн үйлдвэрлэлийн хоршоо нь гишүүдийн түүхий эдийг авч түүнд үндэслэн үйлдвэрлэл явуулдаг хэлбэртэй байж болдог. Үйлдвэрлэлийн хоршооны үйлчилгээ нь нийтэд нээлттэй байдаг.

¹⁹ Б.Зарыккан. Хоршооны тайлбар толь лавлах, 2004.

²⁰ ОУХБ, Хоршооны тухай хууль тогтоомж боловсруулахад зориулсан зөвлөмж, 2005.

Үйлчлэн зуучлах ба үйлдвэрлэлийн хоршоодыг дээрхи ангилалын хүрээнд зорилго, эрхэлж буй үйл ажиллагааны төрлөөс шалтгаалан дараах төрлүүдэд хувааж болно:

- эд хэрэглэгчдийн хоршоо;
- даатгалын хоршоо;
- хангамж бэлтгэн нийлүүлэлтийн хоршоо;
- борлуулалтын хоршоо;
- үйлчилгээний хоршоо;
- хадгаламж зээлийн хоршоо;
- түүхий эд боловсруулалтын хоршоо;
- хөдөө аж ахуйн хоршоо ;
- харилцан туслалцах хоршоо;
- орон сууцны хоршоо ;
- ажилчны хоршоо;
- олон төрөлт хоршоо;
- бүрэн хоршоо.

1.1.3. Хоршооны үйл ажиллагааны төрөл

Хоршооны эрхлэх аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээг хоршооны үйл ажиллагаа гэх бөгөөд түүний чиглэл, төрөл зүйлийг үйл ажиллагааны төрөл гэнэ. Манай улсын Хоршооны хуулийн дагуу хоршоо нь дараах төрлийн үйл ажиллагаа эрхэлж болно:

- түүхий эд боловсруулалтын;
- үйлдвэрлэлийн;
- хадгаламж зээлийн;
- борлуулалт, хангамж, бэлтгэн нийлүүлэлтийн;
- үйлчилгээний;
- орон сууц барих зориулалтын;
- эд хэрэглэгчдийн;
- дүрэмд заасан бусад үйл ажиллагаа.

Түүнчлэн хоршоо нь хэд хэдэн үйл ажиллагааг нэгэн зэрэг эрхэлж болох бөгөөд энэ нь хуулиар хориглоогүй ямарч үйл ажиллагаа байж болно. Олон төрлийн үйл ажиллагааг нэгэн зэрэг эрхэлдэг хоршоог олон төрөлт хоршоо гэж нэрлэдэг. Дэлхийн практикт хоршоо нь ОУ-ын гэрээ, хэлэлцээр, тухайн орны хуулиар хориглоогүй үйл ажиллагааг түгээмэл эрхэлж байна. Тухайлбал: газар түрээслэх, хадлан бэлчээрийн, дуудлага худалдааны, жимсний, намаг хатаах, орон сууц барих, тахир дутуу хүмүүсийн, ус сувгийн, ой модны аж ахуйн, зохиомол хээлтүүлгийн, атар эзэмших, намаг хатаах, загас агнуур, боловсруулалтын, ажиллах хүч хуваарилах буюу хөдөлмөрийн, хяналтын, хөдөө аж ахуйн машины, даатгалын, цахилгаан хангамжийн, иргэдийн үйлчилгээний, сургалтын гэх мэт тухайн орон нутагтаа зайлшгүй шаардлагатай үйл ажиллагааг хоршоод эрхэлдэг байна.

1.1.4. Хоршооны эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын Иргэний хууль (2002) нь суурь хуулийн нэг бөгөөд иргэний эрх зүйн харилцаанд оролцогч иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага буюу эрх зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулдаг.

Иргэний хууль тогтоомж нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх үүргийг ямар нэгэн хязгаарлалтгүй, хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалагдах зарчмыг үндэс болгодог.

Иргэний хуулийн энэхүү зарчим, заалтуудын дагуу хоршоо болон түүний гишүүн /иргэн/ нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогч бөгөөд иргэн, хуулийн этгээд, төлөөлөл, хэлцэл, барьцаа, гэрээ, үүрэг, арилжаа, зээл, тооцооны үүрэг, хөрөнгө шилжүүлэх, санхүүгийн лизинг, газрын түрээс зуучлал, хадгалуулах, даатгал, эдийн ба эдийн бус баялагийн эрх, эзэмшил, өмчлөх эрх, өв залгамжлал, зөрчлийн улмаас үүсэх үүрэг зэрэг харилцааг зохицуулдаг учир түүнийг үйл ажиллагаандаа байнга мөрдлөг болгож байх нь хоршооны зорилгыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Энэ хуульд хоршоотой холбоотой хэд хэдэн онцлог заалт байдаг. Үүнд:

- Насанд хүрээгүй буюу 14 - 18 насны этгээдийг иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай гэж үздэг боловч хоршооны хувьд 16 - 18 насны иргэн хоршооны гишүүн байхыг зөвшөөрсөн;
- Хуулийн этгээдийн болон хоршооны тодорхойлолт өгч, хоршоо дүрэмд заасан зорилготой, ашгийн төлөө бус хуулийн этгээд гэдгийг баталгаажуулсан;
- Ашгийн төлөө бус хуулийн этгээд өөрийн дүрэмдээ заасан үйл ажиллагааг явуулахаар заасан нь хоршоо олон төрлийн үйл ажиллагаа эрхлэх үндсийг тавьсан;
- Хоршоог үүсгэн байгуулах, бүртгэх, үйл ажиллагаагийн дуусгавар болгох, гишүүнчлэл, хяналт болон хоршоотой холбоотой бусад харилцааг хуулиар зохицуулахыг хуульчилсан;
- Хэд хэдэн хуулийн этгээд нь үйл ажиллагаагаа зохицуулах зорилгоор нэгдэж болох бөгөөд нэгдлийн оролцогчид хуулийн этгээдийн эрхээ хадгалах тухай заалт орсноор дундын хоршоо байгуулахад хоршоо бус хуулийн этгээд оролцох боломжтой болсон;
- Энэ хуулийн зээл, хадгаламжтай холбогдсон заалтуудыг хадгаламж зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг хоршоод шууд мөрдөх боломжтой.

Монгол Улсын дараахь хуулиуд хоршооны үйл ажиллагаатай шууд ба шууд бусаар холбогдож, эрх зүйн харилцааг зохицуулдаг:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Хоршооны тухай хууль
- Нягтлан бодох, бүртгэлийн тухай
- Улсын Засгийн газрын тухай
- Банкны тухай
- Аудитийн тухай
- Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах тухай
- Татварын Ерөнхий
- Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай
- Хүн амын орлогын албан татварын тухай
- Худалдааны албан татварын тухай
- Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай
- Онцгой албан татварын тухай
- Тэмдэгтийн хураамжийн тухай
- Нийгмийн даатгалын тухай

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

- Мөнгөн хадгаламж, төлбөр, тооцоо, банкны үйл ажиллагааны тухай хууль
- Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай
- Хүнсний тухай
- Газрын тухай
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
- Бусад хуулиуд

Хоршоо нь үйл ажиллагаатайгаа холбогдох хууль түүний заалтыг нарийвчлан судлаж, мөрдөж ажиллах, гишүүдийнхээ хуулийн мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ авах үүрэгтэй.

1.2. Олон улсын байгууллагуудаас гаргасан зохицуулалтууд

1.2.1. Нэгдсэн Үндэсний Байгууллагын тогтоол

НҮБ -ын 5 4-р Ерөнхий Ассамблейн 54-р чуулганд дэлхийн 34 орон “Нийгмийн хөгжилд хоршооллын гүйцэтгэх үүрэг” тогтоолыг санаачлан оруулж нийтийн тохиролцоогоор батлуулжээ. (Хавсралт 1.)

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1992 оны 12-р сарын 16-ны өдрийн 47/90 тоот тогтоолоор жил бүрийн 7-р сарын эхний долоо хоногийн бямба гарагийг ОУ-ын хоршооллын өдөр болгон тунхаглаж, түүнийг тэмдэглэж байхыг Засгийн газрууд, ОУ-ын холбогдох байгууллага, төрөлжсөн байгууллага, орон нутгийн үндэсний болон ОУ-ын хоршооллын байгууллагуудад уриалжээ.

1.2.2. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага

2002 онд Женев хотноо хуралдсан Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-ын Ерөнхий бага хурлын 90-р хуралдаанаараа “Хоршооллын хөгжилд дэмжлэг үзүүлэх тухай” 193-р зөвлөмжийг батлсан.

Энэхүү зөвлөмжөөр ажлын байр бий болгох, нөөцийг дайчлах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, бүх хүн ам эдийн засгийн болон нийгмийн хөгжилд арай илүү бүрэн оролцоход хоршоодын хэлбэрүүд дэмжлэг үзүүлдгийг болон даяарчлалын нөхцөлд хүмүүсийн эв нэгдлийг бий болгоход хоршоо илүү боломжтойг хүлээн зөвшөөрч, хэд хэдэн зүйлүүдийг зөвлөснийг авч үзье.

(ОУХБ) -ын зөвлөмжөөр “хоршоо” гэдэг хэллэг бол өөрсдийн эдийн засаг нийгмийн ба соёлын хэрэгцээгээ хангахын тулд ардчилсан хяналт, удирдлагатай, үйлдвэрийг хамтран эзэмших сонирхолтой, сайн дурын үндсэн дээр нэгдсэн хүмүүсийн биеэ даасан эвлэл, холбоо гэсэн үг юм. Хоршооны бие даасан байдлыг хангах ёстой. Үүнд:

1. хоршоодын үнэт зүйлс, бие биедээ туслах хариуцлага, ардчилал, тэгш эрх, нэгдэл нягтрал, шудрага байдал, ес суртахууны хэм хэмжээ,
2. хоршооны зарчмуудыг хэрэгжүүлэх.

Мөн зөвлөмжөд дараахь асуудлыг тусгасан байна:

- Тухайн улсын хөгжлийн түвшингээс хамааралгүйгээр хоршооллын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах, тусламж үзүүлэх;
- Өөрсдийн байгууллагын болон нийгмийн, хүн амын ядуу хэсгийн хэрэгцээг хангах зорилготой тусгай арга хэмжээг авах ажлыг хөхиүлэн дэмжих;
- Засгийн газар хоршооллуудын шинж чанар ба үйл ажиллагаанд нь тохирсон

- бодлого явуулж, эрх зүйн хэм хэмжээг зохицуулах;
- Засгийн газар нь нөхцөл байдлаас шалтгаалан хоршоодын үйл ажиллагааг тодорхой чиглэлээр (ажлын байр бий болгох, хүн амын ядуу хэсгийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагааг хөгжүүлэх, хоцрогдсон зах хязгаарыг хөгжүүлэх) дэмжих, бусад үйлдвэр, аж ахуйн газраас дутахааргүй тохиромжтой, аятайхан нөхцлүүдийг бүрдүүлэх, өөрийн боломжоор татварыг хөнгөлөх, зээл олгох, нэмэлт нөхвөр олгох, нийгмийн ажлын хөтөлбөрт оролцуулах, онцгой нөхцөлөөр бараа таваар худалдаж авах боломжийг хангах;
 - Үндэсний улс төрийн бодлогыг дараах зүйлд чиглүүлэх. Үүнд:
 1. хоршоололд хэн ч байсан ялгаварлан гадуурхагдахгүй байх,
 2. хөдөлмөрийн хуулийг зөрчих, далд хөдөлмөрийн харьцаа тогтоохын тулд хоршоолол байгуулах, хоршооллыг ашиглах явдлын эсрэг нөхцлийг бүрдүүлэх, ажилчдын хөдөлмөрийн эрхийг зөрчиж буй хоршооллуудтай тэмцэх,
 3. хоршоололд тэргүүний арга барил нэвтэрүүлэх;
 4. гишүүд, удирдлагын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, мэдлэгийн түвшинг дээшлүүлэх;
 5. нийгмийн ба ерөнхий боловсрол, мэргэжлийн сургалтын үндэсний системд хоршооллын зарчим, аргын асуудлаар сургаж бэлтгэх;
 6. хоршооллын зээл ашиглах, зах зээлд нэвтрэх боломжийг хөнгөвчлөх;
 7. хоршооллын талаар статистик тооцооны үндэсний системийг сайжруулах;
 - хоршооллын үйл ажиллагааг өөрчлөн сайжруулахад дэмжлэг үзүүлэх;
 - хоршооллын холбогдолтой хууль, бодлогод өөрчлөлт оруулахдаа хоршооллын зарчмыг үндэс болгох, хоршооллын байгууллагуудтай зөвшилцөх;
 - Засгийн газар хоршооллыг бэхжүүлэхийн тулд ажилд нь туслах, аж ахуйн үйл ажиллагаа явуулах чадварыг дээшлүүлэх, ажлын байр, орлого бий болгох, нөөцийг нэмэгдүүлэх боломжийг албадаар дамжуулан нэмэгдүүлэх, орон нутагт хоршоодыг байгуулах, бэхжүүлэхэд чиглэгдсэн зохих механизмийг хөгжүүлэх;
 - Засгийн газар хоршоодод зээл, эд хөрөнгийн эх үүсвэр олгох боломжийг бий болгох араг хэмжээ авах үүрэг хүлээх ёстой;
 - Засгийн газар хоршоо хооронд туршлага солилцох, орлого, эрсдэлийн хуваарилалтыг хөнгөвчлөх, хоршоо хоорондын санхүү, техник, худалдааны холбоо хөгжүүлэх таатай нөхцөл бий болгох ёстой;
 - Ажил олгогч ба ажиллагсдын байгууллага хоршооллын тогтвортой хөгжлийн төлөө хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх, хоршоод болон ажиллагсдыг урамшуулах,
 - ОУ-ын хамтын ажиллагаанд зуучлах дэмжлэг үзүүлэх;

1.2.3. Олон Улсын Хоршооллын Альянс

1895 онд Лондон хотноо Олон Улсын Хоршооллын Альянс²¹ (ОУХА) байгуулагдсан. ОУХА нь ОУ-ын хоршооллын үндэсний холбоод, хоршооллын бусад байгууллагуудыг нэгтгэж, тэднийг төлөөлөх, тэдэнд үйлчлэх, хоршооллын хөдөлгөөнийг хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлдэг, бие даасан ОУ -ын ТББ юм. ОУХА -ийн 100 жилийн ойг 1995 онд Англи улсын Манчестер хотноо бага хурал хийж тэмдэглэн тунхаглал гаргасан. ОУХА-д дэлхийн 100 гаруй орны үндэсний хоршооллын байгууллагууд, ОУ -ын 9, улс, үндэсний 22 байгууллага

²¹ International Co-operative Alliance

гишүүнээр элссэн бөгөөд эдгээрт 800-гаад сая хоршооны гишүүд хамрагдаж байгаа нь гишүүдийнхээ тоогоор аль ч төрийн бус байгууллагуудаас хол давсан, ОУ-ын хүчирхэг байгууллага болсон байна.

ОУХА нь 1946 онд НҮБ-д зөвлөх статус бүхий анхны Засгийн газрын бус байгууллага болжээ. Хоршооны гишүүдийн гэр бүлийг оролцуулан тооцвол нийтдээ 3 тэрбум орчим хүн хоршооны хөдөлгөөнд хамрагдаж, үр ашгийг хүртэж байна. Манай улсаас анх удаа Монголын эд хэрэглэгчдийн хоршоодын төв холбоо 1993 онд гишүүнээр элссэн байна.

ОУХА нь дараах зорилтуудыг удирдлага болгодог:

- өөрийн үйл ажиллагаанд хоршооны эрчмуудыг мөрдлөг болгодог бүх төрлийн хоршооллын байгууллагыг дэлхийд төлөөлөх;
- хоршооны зарчим, арга ажиллагаа, үзэл санааг дэлхийн хэмжээнд сурталчлах;
- хоршооллын хөдөлгөөнийг ашиг сонирхлыг түүний бүх хэлбэрээр хамгаалах;
- бүх дэлхийд хоршооллыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; өөрийн бүрэлдхүүнд байгаа байгууллагуудын хоорондын найрамдалт харьцааг дэмжих;
- бүх төрлийн хоршооллын байгууллагуудын хоорондын эдийн засгийн харилцааг үндэсний болон ОУ-ын хэмжээнд хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- бүх орнуудын ард түмний эдийн засаг, нийгмийн дэвшилд өөрийн хувь нэмрийг оруулах;
- бат бэх энх тайван аюулгүй байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх.

1995 онд ОУХА-ийн их хурлаас өнөө үед баримтлах ОУ -ын хоршооны үндсэн зарчимуудыг²² баталсан.

* * *

Олон улсын хоршооны үндсэн зарчим

1-р зарчим.

Сайн дурын нээлттэй гишүүнчлэл

Хоршоо сайн дурын байгууллага бөгөөд түүний үйлчилгээг гишүүдийнхээ хариуцлагыг хүлээх чадвартай хэн бүхэн ашиглах боломжтой. Гишүүдийг хүйс, нийгмийн байдал, шашин шүтлэг, арьс өнгө, улс төрийн үзэл бодлоор гадуурхахгүй, хэн боловч гишүүнээс өөрийн хүсэлтээр гарч, дахин элсэх эрхтэй.

2-р зарчим.

Гишүүдийн ардчилсан удирдлага, хяналт

Хоршоо нь бодлого чиглэл, шийдвэр гаргахад идэвхтэй оролцогч гишүүдийн байгууллага юм. Сонгуулиар үүрэг хүлээсэн эрэгтэй, эмэгтэй ямар ч хүн бүх гишүүдийн өмнө тайлан тавина. Анхан шатны хоршоонд гишүүд санал өгөх тэгш эрхтэй байдагтай адил бүх шатны хоршоог ардчилсан хэлбэрээр зохион байгуулна.

3-р зарчим.

Гишүүдийн эдийн засгийн оролцоо

Гишүүд хоршооныхоо хөрөнгийг аль болох тэнцүү хэмжээгээр бүрдүүлж, ардчилсан хяналт тавина. Ямар ч тохиолдолд энэхүү

²² <http://www.ica.coop/coop/principles.html>

хөрөнгийн зарим хэсэг нь хоршооны нийтийн өмч байна. Гишүүд орлогыг дараах зориулалтаар хуваана: Хоршоог хөгжүүлэх нөөц сан байгуулах; Гишүүдийн ноогдол орлого; Гишүүдийн зөвшөөрсөн бусад арга хэмжээ.

4-р зарчим.

Хоршооны бие даасан байдал

Хоршоо, гишүүдийн хяналтад байдаг, бие даасан, өөртөө туслах байгууллага юм. Хэрэв тэд өөр байгууллагатай гэрээ байгуулах эсвэл гадны эх үүсвэрээс хөрөнгө эргэлтэнд оруулбал юуны өмнө гишүүдийн ардчилсан хяналтын дор, хоршооны бие даасан тусгаар байдлыг хангахаар тохирч тусгуулна.

5-р зарчим.

Боловсрол, сургалт, мэдээлэл

Хоршоо нь гишүүд, удирдлага, ажилтнуудынхаа хоршооны хөгжилд оруулах хувь нэмрийг ахиулах зорилгоор тэднийг боловсрол олгох сургалтад хамруулна. Тэд олон нийтийн ялангуяа залуучууд, тэргүүлэх ажилтнуудад хоршооны ашиг тус, мөн чанарыг ойлгуулна. Хоршоонд сургалт, мэдээллийг дэмжих зорилгоор боловсрол, мэдээллийн хороо, боловсрол, сургалтад зориулсан сан байгуулж болно.

6-р зарчим.

Хоршоод хоорондын хамтын ажиллагаа

Хоршоод өөрийн гишүүдэд аль болохоор үр ашигтай үйлчлэхийн зэрэгцээ орон нутаг, олон улсын түвшинд хамтарч ажилласнаар хоршооллын хөдөлгөөнийг улам бэхжүүлнэ. Үүний тулд дундын хоршоонд элсэнэ, хоршоодын холбоонд эвлэлдэн нэгдэнэ, эдийн засгийн гадаад харилцаанд бие даан орно.

7-р зарчим.

Нийтийн эрх ашиг

Хоршоо гишүүдийнхээ батламжилсан бодлогоор дамжуулан оршин буй орон нутгийнхаа тогтвортой хөгжлийг хангахын төлөө ажиллана.

Эдгээр үндсэн 7 зарчмын заримыг нарийвчлан авч үзье.

2 -р зарчим. Гишүүдийн ардчилсан хяналт:

- Гишүүн бүр оруулсан хөрөнгөөсөө үл хамааран саналын нэг эрхтэй байна.
- Хоршооны дээд удирдах байгууллага нь бүх гишүүдийн хурал байна.
- Зөвхөн олонхоорооо шийдвэр гаргана.
- Үүсгэн байгуулагчид ба элссэн гишүүд тэгш эрхтэй байна.
- Хоршоог зөвхөн хоршооны гишүүд хянан шалгах эрхтэй.
- Гишүүд хоршооны удирдлагын болон санхүүгийн үйл ажиллагааны талаар хэзээ ч мэдээлэл авах, шаардлагатай гэж үзвэл бүх гишүүдийн хурлыг гишүүдийн санаачлагаар хуралдуулах эрхтэй.

3 -р зарчим. Гишүүдийн эдийн засгийн оролцоо:

Гишүүд орлогоо нэмэгдүүлэх гэсэн нэгэн зорилгод санаа нийлэн хоршоо байгуулдаг учир



хоршооны санхүү, эдийн засгийн байдлыг сайжруулахыг байнга эрмэлздэг нь тэдний язгуур эрх ашигтай шууд холбоотой юм. Гишүүн анх хоршоонд элсэхэд хувь хөрөнгөө нийлүүлэн, татвар төлж элсдэг нь хоршооны санхүүгийн гараа болж өгдөг. Хоршооны гишүүдийн хувь нийлүүлэх хөрөнгийн хэмжээг тогтоохдоо заавал нийлүүлэх доод хэмжээ, нийлүүлж болох дээд хэмжээ гэж ангилан дүрэмдээ тусгадаг бөгөөд доод хэмжээг хоршоонд элссэн хүн бүр хувь нийлүүлэх үүрэгтэй бөгөөд дээд хэмжээг сонирхсон гишүүд л нийлүүлж болно. Үүгээр санхүүгийн бүх асуудлыг шийдвэрлэх боломжгүй.

Хоршооны гишүүдийн тоо тогтвортой бус, гишүүн бүр нь хоршоонд санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломжгүй, хувь нийлүүлэх хөрөнгө нь хязгаартай байгаа нь хоршооны санхүүгийн чадавхи сул байх үндэслэл болдог. Түүнчлэн гишүүд хоршоондоо нэмэлт хувь нийлүүлэх боломжтой боловч тэр нь гишүүдийн саналын эрхийг нэмэгдүүлдэггүй учир үр ашигтай хөрөнгө оруулалт гэж үздэггүй. Хоршооны санхүүгийн боломжийг нэмэгдүүлэхийн тулд зарим оронд гишүүдээс хоршоонд хөрөнгө оруулах доод хэмжээг тогтоож, түүнийг нөхөн төлдөг практик бий. Гишүүдийн эдийн засгийн оролцооны нэг хэлбэр нь гишүүдэд үл хуваагдах нөөц санг заавал байгуулж, түүнийг тогтвортой байдлын баталгаа болгох, ашиглахаас гадна сайн дураар татан буугдахаас сэргийлэх явдал мөн.

Хоршооны үйл ажиллагааны үр дүнд бий болсон хөрөнгө нь хоршоологчдын дундын өмч болно. Хоршоо цэвэр орлогоо хоршооны гишүүдэд ногдол ашиг болгож хуваарилахаас гадна хоршоогоо хөгжүүлэх, эд хөрөнгөө аривжуулах, хөрөнгө оруулалт хийх зэргээр хоршооныхоо үйл ажиллагааг дэмжихэд зориулан цэвэр орлогынхоо зохих хувийг төрөл бүрийн сан болгон үлдээхээр бүх гишүүдийн хурлаас шийдвэрлэж болно.

4-р зарчим. Хоршооны бие даасан байдал:

Өөрөө өөрийгөө удирдаж, хараат байдалд орохгүй, өөртөө засах байдалтай байхыг хэлнэ. Энэ нь хоршооны баримталбал зохих гол зарчмын нэг болно. Хоршоо өөрөө өөрийгөө тэтгэж, гишүүдийнхээ удирдлага, хяналтын дор ажилладаг, гишүүддээ туслан үйлчилж, орлогын нэмэгдүүлэх зорилготой байгууллага учир хараат бус байх ёстой. Хоршооны бүх удирдлагыг гишүүдээс нь сонгож ардчилсан хяналт тавьж, тэд нь гишүүддээ тайлагнаж, хоршооны Тэргүүлэгчид бүх гишүүдийн хурлаас тогтоосон журмаар хязгаарлагдмал эрх эдлэж байгаа нь түүний бие даасан байдлын баталгаа болно. Хоршоо нь бусад байгууллагатай гэрээ, хэлцэл байгуулж, санхүүгийн үйл ажиллагаа явуулахдаа гадны хөрөнгийг ашигладаг боловч, энэ нь гишүүдийн хяналтын дор бие даасан байдалд дарамт учруулахааргүй байх ёстой. Түүнчлэн төрөөс үзүүлж байгаа дэмжлэг нь тухайн хоршооны хүчин чадалд тохирсон байвал зохино.

5-р зарчим. Боловсрол, сургалт, мэдээлэл:

Хоршоо өөрийгөө хөгжүүлэхэд үр бүтээлтэй хувь нэмэр оруулах нөхцлийг бүрдүүлэхийн тулд гишүүд, сонгуультай гишүүд, удирдах ажилтнуудаа сургалтанд хамруулан мэргэжил, боловсролыг нь дээшлүүлэх үүрэгтэй. Түүнчлэн хоршоо өөрийн онцлог, давуу талыг иргэдэд ойлгуулахын тулд нийтэд байнга сурталчилж байна. Ялангуяа хоршооны гишүүдийн тоог нэмэгдүүлэх, хоршооны үзэл санааг түгээн дэлгэрүүлэх замаар орон нутагт ажилгүйдлийг бууруулах, ирээдүйн хоршоологчдыг бэлтгэхийн тулд залуучууд, эмэгтэйчүүдийн дунд сургалт, сурталчилгааг байнга, тогтмол явуулна. Хоршоо өөрөө хоршооны мэдлэг, боловсрол өгөх төв болж, өөртөө бусдыг татах бодлогоо үргэлж явуулах нь чухал.

6-р зарчим. Хоршоод хоорондын хамтын ажиллагаа:

Хоршоод өнөөгийн зах зээлийн эдийн засгийн нөхцөлд ганцаараа ажиллаж тодорхой зорилгоо хэрэгжүүлж чадах нь эрсдэлтэй. Ийм учраас орон нутаг, аймаг, бүс нутаг, үндэсний болон улс хоорондын хүрээнд хамтран ажиллаж, хоршооллын хөдөлгөөнд нийлэн, түүнийг бэхжүүлэх замаар гишүүдийн ашиг сонирхолыг хамгаалж, тавьсан



зорилгоо хэрэгжүүлж чадна. Үүнд дараахи хэлбэрүүдийг ашиглаж болно:

- Өөр хоршоо, хуулийн этгээдтэй хамтран хоёрдогч, гуравдагч шатны дундын хоршоо байгуулах;
- Хоршоодын мэргэжлийн холбоод байгуулах, гишүүнээр элсэх;
- Аудитийн хоршоо, холбоонд гишүүнээр элсэх;
- Аймаг, бүс нутгийн холбоодод нэгдэх;
- Орон нутгийн болон өөр аймаг, бүс нутгийн хоршоодтой түншлэлийн харилцаа тогтоож, хамтран ажиллах;
- Эдийн засгийн болон бусад чиглэлийн төсөл, сангуудтай хамтран ажиллах;
- Худалдааны, хадгаламж зээлийн гэх мэт тодорхой үйл ажиллагаагаар сүлжээ байгуулах, түүнд оролцох;

7-р зарчим. Нийгмийн сонирхол:

Хоршоо нь гишүүдийнхээ хэрэгцээг хүндэтгэн тэдгээрийн эрх ашиг сонирхолыг ямагт хамгаалж, нийгмийн дэвшил, хөгжлийн төлөө ажиллана. Хоршоо нь гишүүдийн эдийн засгийн болон нийгэмд эзлэх байр суурийг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд хүмүүсийн харилцан бие биедээ үйлчлэх, хариуцлага хүлээх, ардчилсан зарчмыг баримтлах, шударга байх, харилцан тэгш эрх эдлэх, нийгмийн шударга ёс журмыг дээдлэх үндсэн нөхцлийг бий болгодог. Ингэснээрээ хоршоо нийгэмд үйлчилж, хоршооны гишүүд тухайн нийгмийн иргэн учир нийгэм өөрөө хоршоог хөгжүүлэх, дэмжих сонирхолтой байдаг. Хоршоо нь өөрийн оршиж байгаа орон нутагт ажил, үйлчилгээ явуулснаар тухайн нутаг дэвсгэрийн нийгмийн асуудлыг шийдэхэд чухал хувь нэмэр оруулдаг.

Хоёрдугаар бүлэг.

ХОРШООНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

2.1. Хоршооллох хөдөлгөөны хөгжил

Хоршиж амьдрах үзэл санаа эрт үүсч, энэ нь хүн төрөлхтөний хөгжлийн үе шат бүрт янз бүрийн хэлбэрээр илэрч байсан. Таваарын харилцаа хөгжих тутам хөдөлмөр, хөрөнгөө нэгтгэн амьдралаа сайжруулах зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа эрхлэн нарийн зохион байгуулалттай болж ирсний нэг хэлбэр нь хоршоо юм. 18 -р зуунд Европын орнуудад машин үйлдвэрлэл түргэн хөгжиж, ажилгүйдэл, ядуучууд нэмэгдэн, гар урчууд жижиг газрын эзэд тэдгээртэй өрсөлдөх чадваргүй болж, хөрөнгө хүчээ нэгтгэх замаар тэдэнтэй тэмцэж, өөрөө өөрийгөө тэтгэх замыг сонгохоос өөр аргагүй байдалд хүрсэн байна. Энэ үед нийгмийн дотор нийгмийн тэгш бус харилцаа, нийгмийн баялгийн тэгш бус хуваарилалтыг шүүмжлэх, нийгмийг хоршоожуулах либерал үзэл бүрэлдэн бий болсон нь хоршоо албан ёсоор үүсэх хөрс суурийг бүрэлдүүлсэн байна.

Ийнхүү Европ тивд анх өөртөө туслах байгууллага үүссэн нь одоогийн хоршоо юм. 1840-өөд онд Английн Манчестр хотод анхны хэрэглэгчдийн хоршоо байгуулагдсан. 1844 онд байгуулагдсан Рочдейлийн нийгэмлэг нь Европт үүссэн дэлхийн анхны хоршоо гэж үздэг бөгөөд энэ үеэс хоршооны тулгуур зарчмыг бий болгосноор хоршоо нь дэлхий даяар түгэх болсон. Одоогоос 150 гаруй жилийн өмнө Германы Делитц хотын дарга Х.Шультцийн санаачлагаар үүссэн зээлийн хоршоод, Фламерсфельд хотын дарга Ф.Райффайзеней үүсгэн байгуулсан зээлийн байгууллага нь хадгаламж зээлийн хоршоодын эх үүсвэр нь болжээ. Харин 1901 онд АНУ-ын иргэн А.Десжардинкс анхны зээлийн хоршоог Америкт байгуулжээ.

Францад байгуулагдсан хоршоод үйлдвэрлэл, үйлчилгээний хоршоодын эхлэл болжээ.



Европын хоршоод төрийн дэмжлэггүйгээр өөрсдөө аяндаа үүсч хөгжсөн бөгөөд эдийн засгийн хямрал тохиолдох бүрт амьдрах чадвар сайтай байдгаа харуулж чадсан юм. Тухайлбал дэлхийн хоёр дайны дараа хоршооны хөгжлийн цэцэглэлтийн үе байсан нь үүнийг харуулна.

Англи улс өөрийн колони болох Энэтхэг улсаас өр ширээ олж авах, үгүйрч хосорсон тариачдын аж амьдралыг дээшлүүлэх арга зам нь Европт амжилттай хөгжиж байсан хоршоодыг Энэтхэгт байгуулах явдал гэж үзэж Энэтхэгт зориулан 1904 онд зээлийн хоршооны, 1912 онд бүх төрлийн хоршоодын тухай хуулийг батлан гаргаснаар Азийн анхны хоршоод энэ улсад үүссэн гэж үздэг.

Тухайн үед Энэтхэгт хоршоог хөгжүүлэх орчин бүрдээгүй гэж үзэн хоршооны хөгжлийг дэмжих газрууд байгуулж, түүний Регисрар хэмээх албан хаагчид эрхлэн эхлээд голлон сургах, зөвлөлгөө өгөх замаар хоршоодыг дэмжиж байсан бол аажимдаа тэдгээр нь маргаан шүүх замаар хоршооны дотоод ажилд төрийн оролцоог хүчтэй болгосон юм. Энэтхэгийн хоршооны загварыг Ази, Африкийн орнууд импортлон авсан бөгөөд Малайз улс одоо хүртэл хэрэглэсээр байна.

Хоршоод өөртөө туслах байгууллагын хувьд дэлхийд болон тухайн оронд эдийн засгийн хямрал үүссэн үед маш түргэн зохицон тохиолдсон бэрхшээлийг даван туулахад гол үүрэг гүйцэтгэж байжээ. Тухайлбал Европт болсон хөрөнгөтний хувьсгал, дэлхийн I, II дайн болон өнгөрсөн зуунд тохиолдсон дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн хямралуудыг арилгахад хоршооны хөгжлийг ашигласан нь бодит баримт юм. Үүний үр дүнд Энэтхэг, Тайланд, Хятадад гар урлал, үйлдвэрлэлийн жижиг хоршоод, Япон, Индонезид эд хэрэглэгчдийн, загасчдын хоршоод хөгжиж, хүн амыг ажилгүйдлээс аварсан бол Сингапур улс хоршооллын даатгалын талаар амжилтанд хүрчээ.

Умард Европ, Итали, Швейцарь, Японд эд хэргэлэгчдийн хоршоод, Европ, Энэтхэг, Индонез, Хятадад ажилчны хоршоо хүчтэй хөгжиж байна. Үйлчилгээний хоршоодоос Бразилид эрүүл мэндийн, Израйлд тээврийн, Скандинавын орнуудад барилгын чиглэлтэй хоршоодыг хөгжүүлж байна.

Европ тив нь хоршоог практик амьдрал дээр үүсгэн байгуулсан, хоршоог үндэслэгч практик сэтгэгчид, хоршооны тухай үл гүйцэлдэх онолын анхны үндэслэлүүдийг дэвшүүлсэн онолчид төрсөн тив юм. Европын холбооны улсууд эв санааны нэгдлийн үзэл баримтлал нь ажил хэрэгч бизнес эрхлэлттэй ерөөсөө зөрчилддөггүй, энэ хоёрыг хослуулсанаар гайхамшигт амжилтанд хүрч болохыг хоршоодын практик харуулж байна гэж үздэг. Европын хоршоод эрүүл, өрсөлдөөнт эдийн засаг нь шудрага, нийгмийн халамжтай нийгэмтэй зэрэгцэн оршиж чаддагийг харуулж байна. Хоршооны хөгжил нь түүнд оруулсан хэмжээнээсээ илүүгээр тэнд ажиллаж буй хүмүүсийн оролцоогоор тодорхойлогддоггоороо, хөрөнгөн дээр суурилагаас илүү үнэт зүйлээр суурилагдан байгуулагддагаараа бусад аж ахуйн нэгжээс ялгаатайг европын холбоод өнө удаан хөгжлийн явцад баталсан байна.

Европын холбоо нийгмийн өргөн хэмжээний зорилгоо биелүүлэхэд нь хоршоодод туслах арга замуудыг тодорхойлсон Европын том аж ахуй дахь Хоршоод хэмээх зөвлөлдөх баримт бичиг гарган хэрэгжүүлж байна. Даяарчлагдаж байгаа өнөө үед ч хоршооны ач холбогдол улам нэмэгдэж байгаа бөгөөд даяарчлал өөрөө хоршооллын дээд хэлбэрийн нэгэн тусгал юм. Өнөө үед хоршооллын давуу талыг хоршооны гишүүдийн гэр бүлийн гишүүдийг оролцуулан тооцвол дэлхийн хүн амын тэн хагас нь ашиглаж байна.

Өнөөгийн даяарчлалын үед ч Европын хоршоод хэрхэн хөгжүүлэх вэ, хоршоодын эв санааны нэгдэл, бизнесийн үзэл санааг хослуулан эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх бодлого баримтлаж, нийт Европын хоршооны хууль гаргахаар чармайн ажиллаж байна. Дэлхийд том үйлдвэр, компаниуд нэгдэж, хорших болсон хоршооны үзэл санаа дэлгэрч



байгаагийн нэг илрэл юм.

Монгол улсад 1916 онд Анхны үндэсний хоршоо байгуулагдах санал гарч 1921 оны 12-р сард Анхны Эд хэрэглэгчдийн хоршоо байгуулагдсан байна. 1940-өөд он гэхэд бүх сумдад байгуулагдсан байжээ. 1931 оноос Монголд гар үйлдвэрийн хоршоолол үүссэн ба 150 шахам артель байгуулагдсан байна. 1939 оноос ХАА-н хоршоолол байгуулагдаж 255 нэгдэл, 36 нэгдэл дундын хоршоо ажиллаж байжээ. Нэг хэсэг уналтанд ороод байсан ХАА-н хоршоод 1992 оны их хурлаараа МХАА-н хоршоологчдын үндэсний холбоо байгуулан сэргэн ажиллаж байна.

1986 оноос УБ хотод хөдөлмөрийн нөхөрлөлүүд бий болон 150 орчим хоршоо бий болжээ. 1991 оноос үйлдвэрийн хоршоодын үйл ажиллагаа сэргэж эхэлснээр хоршоог шинэ зууны эхэнд түгэн дэлгэрэхэд их нөлөөлсөн гэж үздэг.

Дэлхийн хоршоодын гишүүд тоон хэлээр

Орчин үед дэлхий дахинаа 1 тэрбум хүн буюу 7 хүн тутмын 1 нь хоршооны гишүүн байдаг бөгөөд 3 тэрбум хүн хоршооллын салбарт ажиллан, ашиг тусыг нь хүртэж байна.

- Монгол улсад 2446 хоршоонд 200.000 хүн гишүүнчлэлтэй
- АНУ-д 4 хүн тутмын нэг нь буюу 29000 хоршоонд 350 сая хүн тус тус гишүүнчлэлтэй.
- Аргентин улсад нийт хүн амын 23.5% буюу 9.3 сая хүн 12670 хоршооны гишүүн.
- БНХАУ -д нийт хүн амын 13.4% буюу 180 сая хүн хоршооны гишүүн.
- Боливи улсад хүн амын гуравны нэг буюу 2.9 сая хүн 1590 хоршооны гишүүн.
- Бразил улсад 7.6 сая хүн 7600 хоршооны гишүүн.
- Герман улсад 4 хүн тутмын нэг нь буюу 20 сая хүн хоршооны гишүүн.
- Индонез улсын хүн амын 27.5% буюу 80 сая хүн хоршооны гишүүн.
- Иран улсад 23 сая хүн буюу хүн амын 33% нь 130.000 хоршооны гишүүн.
- Испани улсад хүн амын 15% буюу 6.7 сая хүн хоршооны гишүүн.
- Канад улсад 3 хүн тутмын нэг нь хоршооны гишүүн, тус улсын Күебек хотын хүн амын 70% нь хоршооны гишүүн байна.
- Кени улсад 5 хүн тутмын нэг буюу 5,9 сая хүн хоршооны гишүүн.
- Колумби улсад 4.8 сая буюу хүн амын 10.6% нь 8124 хоршооны гишүү.
- Коста Рика улсын хүн амын 10% нь хоршооны гишүүн.
- Малайз улсад нийт хүн амын 27% буюу 6.7 сая хүн хоршооны гишүүн.
- Норвегийн 4.8 сая хүн амын 2 сая нь хоршооны гишүүн.
- Прагвай улсад хүн амын 18% буюу 783000 хүн 1047 хоршооны гишүүн
- Сингапурт нийт хүн амын 50% буюу 1.6 сая хүн хоршооны гишүүн.
- Уругвайд 3 хүн тутмын нэг нь хоршооны гишүүн.
- Шинэ Зеландад нийт хүн амын 40% нь хоршооны гишүүн
- Франц улсад 23 сая хүн буюу хүн амын 38% нь хоршооны гишүүн.
- Энэтхэгт 239 сая хүн хоршооны гишүүн.
- Япон улсад 3 гэр бүл тутмын нэг нь хоршооны гишүүн.

Хоршооны гишүүдийн тоо 15-60 насны хүн амтай харьцуулахад хөгжингүй орнуудад 20 хувь, шилжилтийн орнуудад 39 хувь, зах зээлийн эдийн засаг хөгжиж буй орнуудад 33 хувьд хүрчээ. Европын холбоо, Африк болон АНУ, Канад, Япон, Энэтхэг, Бразили, Аргентин улсын үндсэн барааны 50 гаруй хувийг хөдөө аж ахуйн хоршоод нийлүүлж байна.

Африк тив болон Энэтхэг, Аргентин зэрэг улсуудын эдийн засгийн зарим салбарт хоршоод ноёлох байр суурьтай бол хөгжиж байгаа ихэнхи оронд хөдөө аж ахуй, хадгаламж зээл, үйлдвэрлэлийн болон хэрэглээний салбарын хоршоод илүү идэвхтэй ажиллаж, эдгээр орны 15-60 насны хүн амын 20 хувь буюу 460 сая хүн хоршооны гишүүн байна.

2.2. Хоршооны тодорхойлолт, зарчим

ОУХА-ын Их хурлаас Манчестерийн гэрээгээр батлан гаргаж дэлхий нийтэд хандан гаргасан зөвлөмжид “Хоршоо гэдэг нь **аж ахуйн өмчийг** хамтран эзэмших, ардчилсан удирдлагын зарчимд тулгуурлах замаар **өөрсдийн** эдийн засаг, нийгэм ахуй, соёлын нийтлэг хэрэгцээ, зорилгод нийцүүлэн сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн хувь хүмүүсийн бие **даасан холбоог** хэлнэ” хэмээн хоршооны тухай ерөнхий тодорхойлолтыг томъёолсон байна.

ОУХБ-аас боловсруулсан зөвлөмжид хоршоог тодорхойлохдоо “Хоршоо нь эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор ардчилсан удирдлага, хамтын өмч дээр тулгуурлан үйл ажиллагаа явуулахаар сайн дураараа нэгдсэн хүмүүсийн бие даасан холбоо” гэсэн байна. Энэ тодорхойлолтын утга санааг Монгол улсын 1998 оны хоршооны тухай хуульд бүрэн тусгасан.

Хоршооны талаарх зохицуулалт бүхий дэлхийн анхны хуулиудын нэг болох Герман улсын 1889 онд баталсан Хоршооны хуулийн 1-р зүйлд: “Хоршоо бол хатуу тогтоогоогүй гишүүдээс бүрдэх ба хамтарсан аж ахуйн үйл ажиллагаа явуулах замаар гишүүдийнхээ эрхлэх аж ахуйд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн нийгэмлэг мөн” гэсэн байна.

Английн колони байсан Энэтхэгийн 1912 оны Хоршооны тухай хуулийн 4-р зүйл: “Хоршоо бол хоршооны зарчмуудад нийцсэн аж ахуйн үйл ажиллагааг гишүүдийнхээ эрх ашгийг дэмжихийн үүднээс явуулж буй нийгэмлэг мөн.” Энэхүү тодорхойлолт Ази, Африкийн зарим орнуудад хүчин төгөлдөр хэвээр байна.

Африк тивийн Франц хэлтэй орнуудын ихэнхэд 1955 оны 455-184 тоот журмаар томъёолсон тодорхойлолт хүчин төгөлдөр байна: “Хоршоо болон хоршоодын холбоо иргэний хуулийн утгаар хүмүүсээс бүрдсэн өвөрмөц нийгэмлэг бөгөөд эдний гишүүдийн тоо ба үндсэн хөрөнгө нь өөрчлөгдөж болно. Үүний гол зорилго бол нийт гишүүдийн эрх ашигт нийцсэн аж ахуйн үйл ажиллагааг өөртөө ашиг хуримтлуулахгүйгээр явуулахад оршиж байна. Улс төрийн бодлого болон шашны талаар шийдвэр гаргах буюу үйл ажиллагаа явуулах нь хориотой.”

Швейцарийн Аж ахуйн эрхийн тухай хуулийн 828-р зүйл: “Хоршоо бол аж ахуйн нэгжээр зохион байгуулагдсан тодорхой бус тооны хүн буюу худалдааны нийгэмлэгийн холбоо бөгөөд гол зорилго нь өөрөө өөртөө туслах замаар гишүүд нь өөрийнхөө аж ахуйн эрх ашгийг хөхиүлэн дэмжиж хамгаалахад оршиж байна. Үндсэн хөрөнгийн хэмжээг урьдчилан хатуу тогтоосон хоршоо хориотой.”

Дэлхийн зарим улсууд хуулиндаа хоршоог тодорхойлсон байдлыг үзвэл дараах нийтлэг зүйлүүд ажиглагдаж байна.

Хүснэгт 1.

Тодорхойлолт	Улс	Холбогдох хуулийн заалт
Нээлттэй гишүүнчлэл бүхий, гишүүдийн тоо хязгааргүй эсвэл байнга өөрчлөгдөж байдаг хуулийн этгээд	- Бельги - ХБНГУ - Унгар	Худалдааны тухай хууль, 350-р зүйл, Хоршооны тухай хууль, 1.1-р зүйл, X/2006, 7-р хэсэг

Гишүүдийнхээ эдийн засаг болон нийгэм, соёлын хэрэгцээг хангах зорилготой	• ХБНГУ • Унгар • Франц • Филиппин • Тайланд	Хоршооны тухай хууль, 1.1-р зүйл, X/2006, 7-р хэсэг Хоршооны тухай хууль, 1.1-р зүйл Хоршооны тухай хууль, 3-р зүйл Хоршооны тухай хууль, 4-р хэсэг
Хамтын өмч, хамтын удирдлага, харилцан туслах зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг	• ХБНГУ • Португал • Тайланд	Хоршооны тухай хууль, 1.1-р зүйл Хоршооны тухай хууль, 2.1-р зүйл Хоршооны тухай хууль, 4-р хэсэг
Зарим цөөн хэдэн улсын хуульд хоршоог хязгаарлагдмал ба хязгаарлагдмал бус хариуцлагатай хоршоо гэж ангилсан	• Бельги • Дани	Худалдааны тухай хууль, 350-р зүйл, 651/2006
Зарим улсын хуульд хоршооллын тухай дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмуудыг мөрдөхийг заасан	• Испани • Португал • Филиппин	27/1999, 1.1-р зүйл Хоршооны тухай хууль, 2.1-р зүйл Хоршооны тухай хууль, 3-р зүйл

Эдгээрээс Франц Улсын хоршооллын эрх зүйн орчныг хөгжлийг дурдая. Тус улсын хоршооны харилцааны ерөнхий зохицуулалт нь 1867 оны Иргэний хууль, Худалдааны тухай хуульд тусгагдсан бөгөөд үүний дараа хоршооны салбар бие даасан хэд хэдэн хуулиуд²³ батлагдан гарчээ. Харин 1947 онд анхны Хоршооны тухай хууль²⁴ батлагдаж, 1992 онд шинэчлэгдэн баталснаар уг харилцааны эрх зүйн орчныг илүү нарийвчилж өгчээ.

1947 оноос хойш Францын хууль тогтоох байгууллага хоршооны салбар бие даасан зарим хуулийг шинэчлэн найруулсаны зэрэгцээ цоо шинэ салбар хуулиудыг батлан гаргажээ. Үүнд: Хадгаламж зээлийн хоршооны тухай (1958), Хадгаламж зээлийн хоршоодын холбооны тухай (1989), Хөдөө аж ахуйн хоршооны тухай (1991), Урчуудын хоршооны тухай (1972), Хоршооллын хамтын сонирхолын тухай (2001), Эмнэлгийн эмч нарын хоршооны тухай (2002) зэрэг хуулиуд байна. Харин ОХУ-д хоршооны эрх зүйн зохицуулалт нь салбар хоршооны хуулиар зохицуулагддаг бөгөөд хоршоог дараах байдлаар тодорхойлсон байна. Хүснэгт 2.

Хуулийн нэр, батлагдсан огноо	Тодорхойлолт
Үйлдвэрлэлийн хоршооны тухай хууль, 1996.04.10	Үйлдвэрийн болон бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэх, дахин боловсруулах, хангах, худалдаа, барилга байгууламж, үйлчилгээ, ашигт малтмал олборлох гэх мэт хуулиар хориглоогүй үйл ажиллагаа эрхлэх хоршоог байгуулах, үйл ажиллагаа явуулах, дуусгавар болгохтой холбоотой харилцааг зохицуулсан
Орон сууцны хуримтлалын хоршооны тухай хууль, 2004.12.22	Хоршоо нь гишүүдийн татварыг нэгтгэх замаар гишүүдийнхээ орон сууцны хэрэгцээг хангах зорилготой хэрэглэгчийн хоршоо байна.
Зээлийн хоршооны тухай хууль, 2009.07.07	Гишүүдийнхээ санхүүгийн хэрэгцээг хангах зорилгоор нутаг дэвсгэрийн, мэргэжлийн болон бусад зарчмаар гишүүнчлэлийн үндсэн дээр иргэд хуулийн этгээдийн нэгдэл байна

²³ Газар тариалангийн зээл ба хоршооны тухай (1908 он), Далайн зээлийн хоршооны тухай (1910 он), Скор-ын тухай хууль (1915 он), Хэрэглэгчдийн хоршооны тухай (1917 он), ард түмний банкууд ба зээлийн хоршооны тухай (1917 он), Урчуудын хоршооны тухай (1923).

²⁴ Хоршооны тухай хууль, 1947.09.10, 47-1775 тоот.

Хөдөө аж ахуйн хоршооллын тухай хууль, 1995.11.15	Хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид хувиараа аж ахуй эрхлэгчид сайн дурын гишүүнчлэлийн үндсэн дээр өөрийн хэрэгцээгээ хангах зорилгоор эд хөрөнгөө нэгтгэн хамтран үйлдвэрлэлийн болон аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг байгууллага байна.
---	--

Гадаадын зарим улсууд ОУХА-аас баталсан ОУ-ын хоршооны үндсэн 7 зарчмуудад тулгуурлан өөрсдийн зарчмыг боловсруулсан байна. Судалгаанд Филиппин болон Франц улсуудын хоршооны зарчмуудыг дэлгэрүүлэн авч үзлээ. Coop France²⁵ буюу Францын хоршооллын холбоо (ФХХ) нь янз бүрийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын хүсэл зоригоор байгуулагдсан бөгөөд тэдний зарчмыг дэмжих, ашиг сонирхлыг нь хамгаалах үүрэгтэй байгууллага юм.

Тус улсын онцлог нь өөрсдийн зарчмыг хуулиар бус харин ФХХ-аас боловсруулсан байна. Ийнхүү 2010 оны 10-р сард ФХХ өөрсдийн тунхаглалыг гаргаснаар ОУХА-ын тунхаглалыг үндэсний хэмжээнд баталгаажуулсан байна.

Францын хоршооллын холбооны зарчмууд

1. Ардчилал

- Удирдлагыг ардчилсан зарчмаар гишүүдээс сонгогдоно.
- Гишүүдийг ялгаварлан гадуурхалгүйгээр саналын нэг эрхтэй оролцоно.

2. Нийтлэг эрх ашиг

- Хоршоолол болон түүний гишүүдийн ашиг сонирхол нийтлэг байна.

3. Хариуцлага

- Түнш, эсхүл сонгуульт үүрэгтэй бүх гишүүд хариуцлага хүлээнэ.

4. Үйлчилгээ

- Хоршоолол нь гишүүдийнхээ эдийн засаг, нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор үйлчилгээ болон бүтээгдэхүүнээр үйлчилнэ.

5. Ойр байх

- Хоршоолол нь бүсийн болон орон нутгийн хөгжлийг дэмжинэ.

6. Ил тод байдал

- Хоршоолол нь гишүүдийнхээ болон хамтын ажиллагаандаа ил тод байдлыг эрхэмлэнэ.

7. Тогтвортой байдал

- Хоршоолол нь одоо болон ирээдүйн залгамж холбоо мөн.

Харин 2008 онд батлагдсан Филиппин Улсын Хоршооны тухай хуулийн²⁶ 4-р зүйлд хоршооны зарчмыг тогтоосон байна. Тус зүйлд “Хоршоо бүр үйл ажиллагаагаа явуулахдаа Филиппиний соёл, үнэт зүйлс, дадал туршлага, мөн дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн дараахь зарчмуудыг мөрдөх үүрэгтэй. Гэхдээ зөвхөн эдгээр зарчмуудад хязгаарлагдахгүй болно.” гэж заасан байна²⁷.

²⁵ <http://www.entreprises.coop/>

²⁶ Филиппин Улсын Хоршооны тухай хууль, 2008/Дугаар 9520, 4-р зүйл.

²⁷ Мөн тэнд.

Филиппин Улсын Хоршооны зарчмууд (Cooperative Principles)**1. Сайн дурын, нээлттэй гишүүнчлэл (Voluntary and Open Membership)**

Гишүүний үүрэг хариуцлагыг хүлээж, үйлчилгээг нь хэрэглэх хүсэлтэй хүн бүхэнд хоршоо нь арьс, хүйс, нийгмийн гарал, соёл, улс төрийн үзэл баримтлал, шашин шүтлэг үл харгалзан нээлттэй байдаг сайн дурын байгууллага юм.

2. Гишүүдийн ардчилсан хэлбэрийн хяналт (Democratic Member Control)

Хоршоо нь ардчилсан байгууллага бөгөөд бодлого боловсруулж, шийдвэр гаргах үйл явцад гишүүд нь идэвхтэй оролцож, хянаж байдаг. Гишүүдийг төлөөлж, удирдах, гүйцэтгэх албанд сонгогдсон хүн бүр гишүүдийн өмнө хариуцлага хүлээдэг. Анхан шатны хоршоодын гишүүд нь нэг гишүүн-нэг саналын эрх гэсэн зарчмын дагуу саналын тэгш эрхтэй. Бусад шатны хоршоод нь мөн ардчилсан зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг.

3. Гишүүдийн эдийн засгийн оролцоо (Member Economic Participation)

Гишүүд нь тэнцүү хэмжээний хувь хөрөнгө нийлүүлж, хоршооны эд хөрөнгийг ардчилсан зарчмын үндсэн дээр хянана. Ийнхүү нийлүүлсэн хувь хөрөнгийн доод тал нь 50 хувь нь хоршооны хамтын хөрөнгийг бүрдүүлнэ. Гишүүд гишүүнээр элсэхийн тулд нийлүүлсэн хөрөнгөөсөө хувь авах бол хязгаарлагдмал хэмжээний хувь буюу нөхөн олговор хүлээн авна. Гишүүд нь илүүдэл хөрөнгөө дараахь зүйлд зориулна.

- Нөөцийн сан байгуулах маягаар хоршоог хөгжүүлэх, ингэхдээ нөөцийн сангийн дор хаяж нэг хэсэг нь хуваарилагддаггүй байх;
- Хоршооны үйл ажиллагааг хэр дэмжиж, оролцож байгааг нь харгалзан гишүүдийг тэтгэж урамшуулах;
- Мөн гишүүдийн хүлээн зөвшөөрсөн бусад үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

(1) Бие даасан, тусгаар тогтносон байдал (Autonomy and Independence)

Хоршоо нь өөрийн гишүүдийн хяналтад байдаг, өөртөө туслах бие даасан байгууллага юм. Засгийн газар болон бусад байгууллагатай гэрээ хэлцэл хийх, эсвэл гадны эх үүсвэрээс хөрөнгө татахдаа гишүүдийн ардчилсан хяналт, хоршооны бие даасан байдлын зарчмыг анхаарч мөрдөнө.

(2) Боловсрол, сургалт, мэдээлэл (Education, Training and Information)

Хоршоо нь сонгогдсон, томилогдсон төлөөлөгч, удирдлагын гишүүн, аливаа ажилтан, гишүүдийг хоршооны хөгжилд зүй зохистой, үр дүнтэй хувь нэмэр оруулах чадвартай болгох зорилгоор сургаж, мэргэжил боловсролыг нь дээшлүүлнэ.

(3) Хоршоод хоорондын хамтын ажиллагаа (Cooperation Among Cooperatives)

Хоршоод нь орон нутаг ба үндэсний, бүсийн нутгийн, олон улсын түвшинд хамтран ажиллаж, хоршооллын хөдөлгөөнийг бэхжүүлж, гишүүддээ хамгийн үр ашигтай үйлчилгээ үзүүлнэ.

(4) Хоршооллын төлөө үйл ажиллагаа явуулах (Concern for Community)

Хоршоод нь гишүүдийнхээ баталсан бодлогын дагуу хоршооллыг тогтвортой хөгжилд хүргэх зорилгоор ажиллана.

2.3. Хоршоодын эрхлэх эдийн засгийн үйл ажиллагааны төрөл, цар хүрээ

Дэлхийн ихэнх орнууд /Австри, Англи, Бельги, Дани, Грек, Испани, Итали, Люксембург,



Нидерланд, Норвеги, Польш, Словак, Унгар Финланд, Эстони/ хууль тогтоомждоо хоршоо нь эдийн засгийн салбарт бүх төрлийн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэж болохыг хүлээн зөвшөөрсөн, өөрөөр хэлбэл ямар нэгэн хязгаарлалт байхгүй байхад бусад орнууд банк, санхүү, даатгалын зэрэг салбарт үйл ажиллагаа эрхлэхийг нь хязгаарласан байна.²⁸

Хүснэгт 3.

Хоршоодын хязгаарлалт	Улс
Давхар даатгал, банк, санхүүгийн үйл ажиллагаа	Болгар
Даатгалын салбар	Герман
Банкны үйл ажиллагаа	Ирланд
Санхүүгийн үйл ажиллагаа	Исланд
Даатгалын салбар	Франц
Давхар даатгал, Банкны үйл ажиллагаа	Чех

Гэхдээ Герман, Франц улсуудад даатгалын салбарт зөвхөн хуульд заасан тусгай хэлбэрээр үүсгэн байгуулсан хуулийн этгээд л үйл ажиллагаа явуулна.

2.4. Хоршоог бүртгэх

Хоршоог аль болох хурдан шуурхай, энгийн, үр дүнтэй аргаар бүртгэх эрх зүйн орчин бүрдүүлэхийг ОУХБ-аас зөвлөсөн байдаг.²⁹ Хоршоог бүртгэсэн өдрөөс эхлэн (эсхүл бүртгэснийг нийтэд мэдээлсэн өдрөөс эхлэн) хоршоо нь эрх, үүрэг бүхий хариуцлага хүлээдэг биеэ даасан хуулийн этгээдийн статустай болно. Хоршоог хуульд заасан шаардлагыг хангасан л бол шууд бүртгэх эсвэл төрийн эрх бүхий байгууллагаас урьдчилан зөвшөөрөл авсны үндсэн дээр бүртгэх гэсэн хоёр арга байдгаас эхнийх нь хамгийн хуульд нийцсэн арга юм. Учир нь төрийн байгууллага зөвшөөрөл олгох эрхтэй байснаар өөрийн үзэмжээр шийдвэр гаргах магадлал ихтэй.

Хоршоог бүртгэх байгууллагын хувьд хоршооны бүртгэлийг компани зэрэг бусад аж ахуйн нэгжийг бүртгэдэг байгууллагад даатгаж, нэгдсэн бүртгэлд хамруулах боломжтой. Эсвэл зөвхөн хоршоог бүртгэдэг тусгай байгууллагад даатгаж болно. Бүртгэлийн үйл ажиллагаа нь захиргааны шинжтэй ажил хэдий ч шүүх байгууллагад даатгаж болохыг Бельги, Грек зэрэг улсын жишгээс харж болно. Европын Холбооны судалгаанд хамрагдсан 30 орноос 2/3 орчимд нь хоршооны тусгай бүртгэл байхгүй бөгөөд бусад хуулийн этгээд, ААН-ийг бүртгэдэг нэгдсэн нэг бүртгэлд хоршоог бүртгэдэг байна.

Хоршоог бүртгэх журмыг тогтоохдоо анхаарах асуудлын нэг нь бүртгэх хугацаа, өөрөөр хэлбэл хоршоо байгуулах хүсэлтийг хүлээн авнаас хойш эрх бүхий байгууллага хэдэн өдрийн дотор хариу өгөх үүрэгтэйг тодорхойлох, энэ хугацаандаа хариу өгөхгүй бол ямар арга хэмжээ авахыг тусгах тухай юм. Хоршоо байгуулах хүсэлтийг хүлээж авснаас хойш тухайлбал Японд 2 сарын дотор, Филиппинд 60 хоногийн дотор, Энэтхэгт 4 сарын дотор бүртгэлийн байгууллагаас хариу өгөх үүрэгтэй байдаг. Хэрэв заасан хугацаанд хариу өгөөгүй бол Филиппинд бүртгэлийг зөвшөөрч, бүртгэсэн хариу өгсөнтэй адилтгаж үздэг байна.³⁰

²⁸ Европын Холбооны судалгаа

²⁹ ОУХБ-ын зөвлөмж, 193/2002, 2.6-р зүйл.

³⁰ Филиппин Улсын Хоршооны тухай хууль, 2008/Дугаар 9520, 16-р зүйл.

2.5. Хоршооны гишүүн

Иргэн ч, хуулийн этгээд ч хоршооны гишүүнээр элсэж болохыг дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрсөн байдаг. ОХУ-ын хоршооны эрх зүйн зохицуулалтын хувьд хоршооны гишүүнчлэл нь хоршооны салбар тус бүрийн хуулиар нарийвчлан зохицуулсан байдаг бөгөөд нийтлэг зохицуулалтын хувьд хоршооны дүрмээр тогтоосон татвараа төлсөн, 16 насанд хүрсэн эрх зүйн чадвар, чадамжтай, ОХУ-ын иргэн байхаас гадна “Зээлийн хоршооны тухай” хуулиар ОХУ-д бүртгэлтэй хуулийн этгээд хоршооны гишүүн байж болно. Хоршооны гишүүнчлэлийн хувьд хоршооны үйл ажиллагааны төрлөөс хамааран Үйлдвэрлэлийн хоршоо 5-аас доошгүй гишүүнтэй байх бол, Орон сууцны хуримтлалын хоршоо нь 50-5000 гишүүнтэй байна.

2.5.1. Хоршооны гишүүдийн тооны доод хязгаар

Монгол улсын Үндсэн хуулийн 16 -р зүйлийн иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг харгалзан үзвэл хоршоо байгуулахад шаардагдах гишүүдийн тооны доод хязгаарыг тогтоохоос зайлсхийвэл зохино. Гэвч хоршоо нь хэд хэдэн этгээдийн нэгдэл бөгөөд үйл ажиллагаагаа хэвийн явуулж, эдийн засгийн хувьд оршин тогтноход нь тодорхой тооны хүн шаардлагатай тул ихэнх орны хууль тогтоогчид хоршооны гишүүдийн тооны доод хязгаарыг тогтоосон байна.

Европын орнуудын хуулийг харьцуулахад хоршооны гишүүдийн тооны доод хязгаар дунджаар 2-7 байна. 10 болон түүнээс дээш байхаар зарим улс тогтоосон байхад зарим улсын хуульд доод хязгаарын тухай огтхон ч дурдаагүй байдаг байна. Тухайлбал Австри улсын хуульд хоршооны гишүүдийн тоог заагаагүй учир доод хязгаар 2 хүн болохыг шууд бус утгаар хүлээн зөвшөөрсөн гэж үзвэл зохино. Азийн орнуудын хувьд хоршооны гишүүдийн тооны доод хязгаарыг Филиппинд 15, Шри-Ланкад 10, ХАА-н хоршооны хувьд Японд 15, Өмнөд Солонгост 20 гишүүн гэж тогтоосон байна.

2.5.2. Хоршоонд гишүүнээр элсэх

Хоршоо нь бүх хүмүүст нээлттэй сайн дурын байгууллага болохыг ОУ -ын хоршооны үндсэн зарчмын 1-д тунхагласан байдаг³¹. Хоршоо нь үйлдвэрлэл, үйлчилгээг нь ашиглах хүсэлтэй хүн бүрт нээлттэй байснаараа хүмүүсийг хамтран ажиллаж, хөгжиж дэвшихэд нь түлхэц болж, нийгэмд зохих хэмжээний үүрэг гүйцэтгэдэг.

Гэхдээ хоршооны гишүүнээр шууд элсэх субьектив эрх гэсэн ойлголт нь хоршоог өөрийн хэрэгцээ сонирхлын үүднээс бие даан, чөлөөтэй үйл ажиллагаагаа эрхлэхэд харшилж байгаа учраас улс орнууд энэ ойлголтоос татгалзсан байна.

Хүснэгт 4.

Хоршоонд гишүүнээр элсэх	Улс
Гишүүнээр шууд элсэх субьектив эрх байхгүй. Хоршооны тэргүүлэгчдийн зөвшөөрөл авснаар элсэх боломжтой.	Герман, Грек, Испани, Итали, Чех, Эстони
Хоршооны дүрэмд гишүүнээр элсэх нөхцлийг заана.	Бельги, Ирланд, Словени, Тайланд, Франц

³¹ ОУХА-аас гаргасан Олон улсын хоршооны баримталах үндсэн зарчим, 1995.

Тухайн хоршоо гишүүнээр элсэх өргөдлийг хүлээн авч, зөвшөөрөл өгөх ба гишүүнээр элсэгч нь хоршооны хувьцаанаас дор хаяж нэг ширхэгийг худалдаж авах ёстой. Хоршооны дүрэмд мэргэжил, оршин суух газар зэрэгтэй холбоотой тусгай нөхцлүүдийг зааж болно.	Австри
Зарчмын хувьд гишүүнчлэл нь нээлттэй ба зарим тохиолдолд тодорхой үндэслэлээр хязгаарлаж болно.	Англи

2.5.3. Хөрөнгө оруулагч - гишүүн элсүүлэх тухай

Энэ нь хоршооны үйл ажиллагаанд хамрагдаж, хамтарч ажиллах эрмэлзэлгүй боловч хоршоонд хөрөнгө оруулж, орлогоос нь хувь хүртэх хүсэлтэй хүмүүсийг хоршооны гишүүнээр элсүүлж байгаа тухай асуудал юм. Нэг талаас хөрөнгө оруулагч-гишүүнийг хүлээн зөвшөөрөхгүй байх нь хоршооны бусад хуулийн этгээдээс ялгарах онцлог хэв шинжийг нь хадгалан хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Гэвч нөгөө талаас хоршоодод үйл ажиллагаагаа хэвийн эрхлэхэд нь бусад хуулийн этгээдийн адил хөрөнгө санхүүгийн эх үүсвэр хэрэгтэй байдаг. Энэ хоёр шаардлагыг хослуулан авч үзээд, аль алийг нь баримталсан тэнцвэртэй шийдэл хүрэх нь чухал юм. Ялангуяа, хөрөнгө оруулагч-гишүүдийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хоршоог удирдаж, хянах боломжийг тэдэнд өгөхгүй байх нь зүйтэй гэж үздэг байна.

Харьцуулсан хүснэгтээс үзэхэд тухайн улсуудын хуульд энэ асуудлыг ерөнхийдөө орхигдуулсан байна. Зарим улсад хөрөнгө оруулагч хуульд заасан үндэслэлээр хоршооны гишүүн болох боломжтой. Гэхдээ үүний хажуугаар хөрөнгө оруулагчид хоршоог хянахаас сэргийлсэн хуулийн хязгаарлалтыг оруулсан байна. Тухайлбал Унгарт хөрөнгө оруулагч-гишүүдийн тоог хязгаарласан бол Италид бүх гишүүдийн хуралд хөрөнгө оруулагч-гишүүдийн өгөх нийт саналын тоог хязгаарласан байна.

Хүснэгт 5.

Хөрөнгө оруулагч-гишүүн элсүүлэх боломж	Улс
Хуулиар зөвшөөрсөн бол хөрөнгө оруулагч элсүүлж болно.	Австри, Бельги, Герман, Испани, Итали, Финланд
Элсүүлж болно. Гэхдээ саналын эрх хязгаартай, мөн элсүүлэхдээ тусгай журмыг мөрдөх зэрэг шаардлага тавьсан.	Англи
Хуульд заасан бол элсүүлж болно. Гэхдээ хөрөнгө оруулагч гишүүдийн тоо хоршооны бүх гишүүдийн 10 хувиас хэтрэхгүй ба хөрөнгө оруулагчдын хувьцааны нэрлэсэн өртөг хувь нийлүүлсэн хөрөнгийн 30 хувиас хэтрэхгүй байх ёстой.	Унгар
Хуульд заасан нөхцлийн дагуу, санал өгөх эрхийг нь хязгаарлах болзолтойгоор элсүүлж болно. Хувь хөрөнгө оруулсан гишүүдийн саналын эрх нийт саналын эрхийн 33 хувь эсвэл 49 хувиас илүү гарах ёсгүй.	Франц
Элсүүлж болохгүй. Гэхдээ хоршоод нь үнэт цаас, бонд гаргаж болно.	Португал
Хуулийн заалт байхгүй.	Болгар, Дани, Ирланд, Чех
Хуулийн заалт байхгүй. Гэхдээ хоршоо нь нэмэлт хувьцаа гаргах эрхтэй гэж заасан байна.	Латви

Хуулийн заалт байхгүй. Гэхдээ цаад утгаараа хөрөнгө оруулагчийг гишүүнээр элсүүлэхийг хүлээн зөвшөөрөөгүй, учир нь хоршооны гишүүд хоршоотой нягт хамтран ажиллах үүрэгтэй ба нийлүүлсэн эд хөрөнгийн хэмжээ нь тухайн гишүүний эрхийг нэмэгдүүлэх зэргээр ямар нэгэн нөлөө үзүүлдэггүй.	Норвеги
Хуулийн заалт байхгүй. Гэхдээ хоршооны гишүүн бус этгээд хөрөнгө оруулж болох ба энэ нь түүнд саналын эрх, хувьсах ноогдол ашиг хүртэх эрх олгохгүй. Давуу эрхийн хувьцаатай адил дэглэм үйлчилнэ.	Швед

2.5.4. Хоршооны гишүүний эрх, үүрэг

Хоршооны гишүүнээр элссэнээр тухайн гишүүн дараахь хувийн ба санхүүгийн шинж чанартай дараахь нийтлэг эрх, үүргүүдийг хүлээдэг. Үүргүүд:

- Хоршооны дүрэм болон бүх гишүүдийн хурлаас гаргасан шийдвэрийг дагаж мөрдөх;
- Хоршооны зорилгод харшилсан үйл ажиллагаа явуулахгүй байх;
- Хоршооны үйл ажиллагаанд оролцох;
- Гишүүн бүр хоршооны дүрэмд заасан тоо хэмжээний хувьцааг худалдаж авах буюу дүрэмд заасан хувь хөрөнгө нийлүүлэх;
- Хоршооны өр төлбөр, алдагдлыг дор хаяж нийлүүлсэн хувь хөрөнгөнийхөө хэмжээнд нөхөж хариуцах;

Эрхүүд:

- Хоршооноос зохих үйлчилгээ авах;
- Бүх гишүүдийн хуралд оролцох, санал өгөх;
- Хоршооны удирдах болон хяналтын зөвлөлийн гишүүнээр сонгох, сонгогдох;
- Хоршооны үйл ажиллагааны талаар аливаа мэдээллийг гаргуулж авах;
- Хоршооны жилийн тайлан болон бүртгэлийн бусад бичиг баримттай танилцах;
- Хоршооны илүүдэл хөрөнгөөс³² хувь хүртэх, эсвэл нийлүүлсэн хувь хөрөнгөөсөө хязгаартай хувь хүртэх³³;
- Гишүүнчлэлээс гарч буй тохиолдолд нийлүүлсэн хувь хөрөнгөө нэрлэсэн өртгөөр эргүүлж авах;
- Хоршоог татан буулгаж байгаа бол хоршооны дүрмээр зөвшөөрсөн тохиолдолд үлдсэн хувь хөрөнгийг хувааж авах.

Европын орнуудын хувьд Ирландаас бусад бүх оронд нэг гишүүн - нэг санал гэсэн дүрэм мөрдөгдөж буй бөгөөд зарим тохиолдолд хоршооны дүрэмд өөрөөр зааж болно гэжээ. Харин Тайланд, Филиппинд мөн нэг гишүүн нэг саналын эрхтэй байдаг байна.

2.6. Хоршооны удирдлага

Хоршоог гишүүд өөрсдөө удирдах нь хоршооны удирдлагын ерөнхий зарчим бөгөөд энэхүү зарчмыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлуудын нэг нь хоршооны удирдлагад зөвхөн хоршооны гишүүд сонгогдох эрхтэй эсэхийг хэрхэн шийдэх тухай юм. Улс орнууд энэ талаар янз бүрийн шийдэлд хүрсэн байдаг. Зарим улсын хууль тогтоомжид энэ

³² 2.7.2-р хэсгээс дэлгэрэнгүйг харна уу.

³³ 2.7-р хэсгээс дэлгэрэнгүйг харна уу.

асуудлыг тусгаагүй, хоршооны дүрэмд тусгахаар заасан байна. Зарим тохиолдолд зөвхөн хоршооны гишүүд удирдах хэсгийн бүрэлдэхүүнд сонгогдох эрхтэй гэж заасан байхад зарим хуульд энэ тухай хориглоогүй байдаг.

Тухайлбал Италийн хуульд аль алийг нь хосолсон шийдэл заасан ч удирдах гишүүдийн олонх нь хоршооны гишүүдээс бүрдсэн байх ёстой гэж заажээ. Солонгост хоршооны удирдах зөвлөл дан хоршооны гишүүдээс бүрдсэн байх ёстой байхад Японд хоршооны тэргүүлэгчдийн тал хувь нь хоршооны гишүүн байх шаардлагатай. Энэтхэгийн хуульд зааснаар зарим тохиолдолд, тухайлбал Засгийн газар хоршооны хувь нийлүүлэгч, эсвэл хоршооны зээл болон бусад төлбөрт баталгаа гаргаж байгаа үед Засгийн газраас тодорхой тооны удирдах гишүүдийг томилох эрхтэй гэж заажээ. Тайландад хоршооны удирдлага бүх гишүүдийн хурлаар сонгогдсон хоршооны гишүүдээс бүрддэг байна.

ОХУ-ын хувьд хоршооны удирдлагын эрх зүйн байдал, үйл ажиллагааны хэлбэр зэрэг зохицуулалтыг тухайн үйл ажиллагааны салбар хуулиар нарийвчлан зохицуулсан байна. Үйлдвэрлэлийн хоршооны тухай хуулиар эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал байх бөгөөд хоршоо нь 50-аас дээш гишүүнтэй тохиолдолд Хяналтын зөвлөл байгуулна. Гүйцэтгэх удирдлагыг хоршооны дарга хэрэгжүүлэх бөгөөд санхүү аж ахуйн үйл ажиллагаанд Хяналт шалгалтын комисс хяналт тавихаар зохицуулсан.

Орон сууцны хуримтлалын хоршоо, Зээлийн хоршоо болон Хөдөө аж ахуйн хоршооллын хувьд эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал байхаар нийтлэг зохицуулсан байна.

2.7. Хоршооны эд хөрөнгө ба хоршооны орлогыг хуваарилах, зарлагыг нөхөх

2.7.1. Хоршооны эд хөрөнгийн доод хэмжээ

Европын улсуудын хууль тогтоомжийг харьцуулахад хоршооны хөрөнгийн доод хэмжээг заагаагүй, эсвэл хоршооны дүрмээр тогтооно гэж заасан байна. Хөрөнгийн доод хэмжээг хуулиар тогтоосон тохиолдолд энэ нь дунджаар 1000 орчим евро байна.

Хоршооны хөрөнгийн доод хэмжээ тогтоох нь зээлүүлэгч зэрэг үүрэг гүйцэтгүүлэгч буюу кредиторыг хамгаалах үүрэгтэй боловч энэ нь хязгаарлагдмал ач холбогдолтой. Учир нь хөрөнгө оруулагч хоршоонд хөрөнгө оруулах шийдвэр гаргахдаа хөрөнгийн доод хэмжээг тогтоосон эсэхийг харахаас гадна үүнээс илүүтэйгээр хоршоонд хуваарилагддаггүй нөөц буй эсэхийг анхаарч үздэг байна. Европын 30 гаруй улсуудад хоршооны хөрөнгийг чөлөөтэй нэмэгдүүлэх, багасгах боломжийг илэрхийлдэг хөрөнгийн тогтворгүй байдлын зарчмыг³⁴ хүлээн зөвшөөрсөн байна. Зөвхөн Дани, Швед улс тодорхой заалт тусгаагүй байна.

Хөрөнгийн доод хэмжээг тогтоосон тохиолдолд хөрөнгийн тогтворгүй байдлын зарчим нь зөвхөн хөрөнгийн доод хэмжээнээс илүү гарсан хэсэгт үйлчилнэ. Хөрөнгийн доод хэмжээг Болгар, Дани, Грек, Их Британи, Ирланд, Нидерланд, Польш, Финланд зэрэг улсууд хуулиараа тогтоогоогүй байна. Герман, Унгар улсуудын хувьд ч хуулиар тогтоогоогүй хэдий ч хоршооны дүрмээр тогтоож болох аж. Хөрөнгийн доод хэмжээний талаар зохицуулалтыг дараах 6 улсууд янз бүрээр шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 6.

Хөрөнгийн доод хэмжээний талаар зохицуулалт	Улс
---	-----

³⁴ Харин компанийн хувьд дүрмийн сангийн дүнг тусгай журмын дагуу багасгах, нэмэгдүүлэх буюу тогтмол байлгах зарчим үйлчилдэг.

Хязгаарлагдмал хариуцлагатай хоршооллын компани бол 18,550 евро	Бельги
Хоршооны дүрмээр тогтооно. Гэхдээ тусгай хуулиудад дунджаар 3000-6000 евро гэж заасан байдаг.	Испани
Хуулиар тогтоогоогүй, гэхдээ гишүүн бүр 25 евро үнэтэй 1 хувьцаа худалдаж авах үүрэгтэй.	Итали
Хуулиар тогтоогоогүй, гэхдээ хоршоо нь ямар ч тохиолдолд үйл ажиллагааныхаа хүрээ, эрсдлийг хариуцах хэмжээний хөрөнгөтэй байх үүрэгтэй.	Норвеги
Тусгай хуульд өөрөөр заагаагүй бол доод тал нь 2500 евро гэж тогтоожээ.	Португал
Хоршооны дүрэмд гишүүд хувийн эд хөрөнгөөр хоршооны үүргийг хариуцна гэж заагаагүй бол хоршооны эд хөрөнгө доод талдаа 2560 орчим евро байх ёстой.	Эстони

2.7.2. Илүүдэл хөрөнгийг зарцуулах болон хуулийн дагуу заавал бүрдүүлэх нөөцийн санд хуваарилах

Илүүдэл хөрөнгө нь хоршооны ашиг, орлогоос ялгаатай ойлголт юм. Хоршоо нь гүйлгээ хийхдээ зах зээлийн эрсдлийг тооцож, үйлдвэр, үйлчилгээнийхээ үнийг нэмж тогтоодог бөгөөд уг зах зээлийн эрсдэл биелээгүй тохиолдолд эрсдлийг тооцож нэмсэн хөрөнгө нь илүүдэл хөрөнгө болдог байна. Илүүдэл хөрөнгийг нөөцийн санд хуваарилах, гишүүдийн нийлүүлсэн хөрөнгөөс хувь олгох, гишүүдэд санхүүгийн тусламж болгон олгох зэргээр зарцуулж болно. Тухайлбал Филиппин улсын хуульд илүүдэл хөрөнгө нь хоршооны ашигт тооцогдохгүй гэж маш тодорхой заасан байна.³⁵

Хоршооны нөөцийн сан бүрдүүлэх нь зээлдүүлэгч зэрэг хоршоогоор үүрэг гүйцэтгүүлэгч этгээдийг хамгаалах зорилготой ба энэ нь ялангуяа хоршооны хөрөнгийн доод хэмжээг хуулиар тогтоогоогүй үед чухал ач холбогдолтой. Мөн нөөцийн сан нь бусад хоршоотой хамтран ажиллах, хоршооллын хөдөлгөөн өрнүүлэх зэрэг үйл ажиллагааг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж өгдөг. Зарим улсын хоршооны тухай хууль тогтоомжид ийм зориулалттай нөөцийн сан заавал бүрдүүлэхийг тусгасан хуулийн заалт байдаг. Нөөцийн санд хуваарилах хувь хөрөнгийн хэмжээг улс орнууд харилцан адилгүй (5-50 хувь) тогтоосон байна.

Хүснэгт 7.

Нөөцийн сан заавал бүрдүүлэх ба хэрхэн бүрдүүлэх талаархи зохицуулалт	Улс
Нөөцийн сан заавал бүрдүүлэх тухай хуулийн заалт байхгүй.	Австри, Дани, Ирланд, Норвеги, Нидерланд
Хоршооны дүрэмд илүүдэл хөрөнгийг хэрхэн зарцуулахыг тусгах ёстой. Хязгаарлагдмал хариуцлагатай хоршооны хувьд жилийн нийт илүүдэл хөрөнгийн 5 хувийг хуульд заасан нөөцийн санд хуваарилах ба ийнхүү хоршооны хөрөнгийн доод хэмжээний 10-тай тэнцэх хэмжээний нөөц хуримтлах хүртэл нэмэгдүүлнэ.	Бельги

³⁵ Филиппин Улсын Хоршооны тухай хууль, 2008/Дугаар 9520, 85-р зүйл.

Хуулийн заалт байхгүй, хоршооны дүрмээр нөөцийн санг тогтоох ба нөөц нь зарчмын хувьд хуваарилагддаггүй.	Герман
Заавал бүрдүүлэх нөөцийн сан, боловсролын сан гэсэн 2 нөөцийн сан байна.	Испани
Жилийн нийт илүүдэл хөрөнгийн 30 хувийг хуулийн дагуу тогтоосон нөөцийн санд ямар нэгэн тооны хязгааргүйгээр хуваарилна.	Итали
Хоршоо нь жилийн нийт илүүдэл хөрөнгийн 10-аас доошгүй хувийг нөөцийн санд хуваарилаж байх үүрэгтэй ба энэхүү нөөцийн сангийн хөрөнгийг хоршооны алдагдлыг нөхөх зэрэгт зөвхөн хэрэглэнэ гэж зориулалтыг нь хуульд тодорхой заасан байна.	Тайланд
Хоршоо нь үндсэн хөрөнгийнхөө 10 хувьтай тэнцэх хэмжээний хуваарилагддаггүй нөөцийн сан бүрдүүлэх үүрэгтэй.	Чех
Хоршоо нь жилийн нийт илүүдэл хөрөнгийн 10-аас доошгүй хувийг (мөн үйл ажиллагаагаа эхэлснээс эхлэн эхний 5 жилд 50 хувиас доошгүй хувийг) нөөцийн санд хуваарилах үүрэгтэй ба энэхүү нөөцийн сангийн хөрөнгийг ямар зориулалтаар хэрэглэх дарааллыг хуульд тодорхой заасан байна.	Филиппин
Хоршоо нь нөөцийн сантай байх ба санхүүгийн жилд олсон илүүдэл хөрөнгийн 5%-иас өмнөх жилүүдийн алдагдлыг хасаад үлдэгдлийг нь санд хуваарилна. Нөөцийн санг хоршооны нийт хөрөнгийн дор хаяж 1 хувьтай тэнцэхүйц хэмжээтэй болтол нэмэгдүүлэх үүрэгтэй.	Финланд
Тусгай хуульд өөрөөр заагаагүй бол төрөл бүрийн нөөцийн сангийн дүн хоршооны хөрөнгийн дүнтэй дүйцэж хүрэхгүй тохиолдолд илүүдэл хөрөнгийн 3/20-аас доошгүй хэсгийг нөөцийн санд хуваарилна.	Франц

Азийн ихэнх орнуудад нөөцийн сан бүрдүүлэхийг хуулиар үүрэг болгосон байх бөгөөд нөөцийн сангийн хөрөнгийг зарцуулахад бүртгэлийн газрын зөвшөөрөл авах хэрэгтэй гэж заажээ. Нөөцийн сангийн хөрөнгө хоршооны гишүүдийн хөрөнгө учраас ийнхүү бүртгэлийн газрыг оролцуулах нь зохисгүй хэрэг юм.

2.7.3. Нөөцийн сангийн хөрөнгийг хуваарилах

Нөөцийн сангийн хөрөнгийг хуваарилах нь дээрх (2.6.2-т заасан) байдлаар бүрдүүлсэн нөөцийн сангийн хөрөнгийг хоршооны үйл ажиллагааны явцад, мөн хоршоог татан буулгах үед гишүүдэд тарааж болох тухай асуудал юм. ОУХА болон ОУХБ-аас гаргасан зөвлөмжөөс үзэхэд нөөцийн сангийн хөрөнгийг хуваариладаггүй, өөрөөр хэлбэл гишүүдэд тараадаггүй байвал зохино гэжээ.

Европын улсуудын хууль тогтоомжийг харьцуулж үзэхэд хэд хэдэн хандлага ажиглагдаж байна.

- Нөөцийн сан бүрдүүлэхийг хуулиар үүрэг болгон заагаагүй ба хоршооны дүрэмд энэ асуудлыг тусгахаар заасан;
- Нөөцийн сан бүрдүүлэхийг хуулиар үүрэг болгон заасан ба нөөцийн сангийн хөрөнгийг гишүүдэд тараахыг зөвшөөрсөн;
- Нөөцийн сан бүрдүүлэхийг хуулиар үүрэг болгон заасан ба нөөцийн сангийн хөрөнгийг гишүүдэд тараахыг хориглосон, гишүүнчлэлээс хасах үед ч тараахыг хориглосон;
- Нөөцийн сан бүрдүүлэхийг хуулиар үүрэг болгон заасан ба нөөцийн сангийн хөрөнгийг гишүүдэд тараахыг хориглосон, хоршоог татан буулгах үед ч тараахыг хориглосон;

- Өөр өөр зориулалттай хэд хэдэн нөөцийн сан бүрдүүлэхийг хуульд заасан.

2.7.4. Гишүүдийн нийлүүлсэн хувь хөрөнгөөс ногдол ашиг хуваарилах

Хөрөнгө оруулагч давамгайлдаг компани аж ахуйн нэгжийн хувьд илүүдэл хөрөнгөө тараахдаа ногдол ашгийн хэлбэрээр тухайн хувь нийлүүлэгчийн оруулсан хувь хөрөнгийн дүн хэмжээнээс хамааран тооцоолж хуваарилдаг.

Хоршоо нь хөрөнгө оруулагч биш, хэрэглэгч давамгайлсан аж ахуйн нэгж учраас илүүдэл хөрөнгө хуваарилах загвар нь өөр ба “буцаан олговрын” хэлбэрээр тараавал зохино гэж үздэг. Буцаан олговрын хэмжээг тооцоолохдоо тухайн гишүүний хоршооны үйл ажиллагаанд хэрхэн оролцож буйг, мөн ямар хувиар (худалдан авагч, худалдагч, ажилтан зэрэг) оролцож буйг харгалзан авч үздэг.

Дээрхээс харахад хоршооны гишүүдийн оруулсан хувь хөрөнгө нь компанийн хөрөнгөөс өөр үүрэг гүйцэтгэдэг байна. Илүүдэл хөрөнгийг тараах нь гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс ашиг гарган эргүүлж хуваарилах бус, харин хоршооны гишүүдийн эдийн засгийн оролцоог шагнах зорилготой болохыг харж болно.

Харьцуулсан хүснэгтээр дараахь асуудлуудыг тодруулсан болно.

- Тухайн улсын хууль нь ногдол ашиг ба буцаан олговрыг ялгаж тусгасан эсэх;
- Ногдол ашиг хуваарилах боломж ба нөхцөл.

Хүснэгтээс үзэхэд Австри, Бельги, Франц, Унгар, Итали, Португал зэрэг улсуудад ногдол ашиг ба буцаан олговор гэсэн хоёр ойлголтыг ялгаж заасан байна. Харин Австри, Ирланд, Герман улсуудад энэ хоёр ойлголтыг хоршооны дүрэмд ялган зааж болно.

Хүснэгт 8.

Ногдол ашиг тараах боломж ба нөхцөл	Улс
Ногдол ашиг хуваарилахыг зөвшөөрсөн, хуваарилах нөхцлийг хоршооны дүрэмд заана.	Австри
Нэг хязгаарлалт байгаа нь тухайн санхүүгийн жил дуусах өдрийн байдлаар хоршооны цэвэр ашиг тухайн тогтмол дүрмийн сангийн дүн эсвэл гишүүдийн оруулсан нийт хувь хөрөнгийн дүнгээс доогуур байгаа тохиолдолд ногдол ашиг хуваарилахыг хуулиар зөвшөөрөөгүй.	Бельги
Ногдол ашиг хуваарилахад хэмжээ нь хязгаартай.	Франц
Ногдол ашиг хуваарилахыг зөвшөөрсөн, хоршооны бүх гишүүдийн хурал тодорхойлно.	Унгар
Зарим төрлийн хоршоод хэрэглэгч- гишүүддээ ногдол ашиг хуваарилахгүй байж болно.	Итали
Нөөцийн санд хуваариласны дараа ногдол ашиг тарааж болох ба ийнхүү тараасан нийт хөрөнгийн хэмжээ тухайн санхүүгийн жилийн нийт илүүдэл хөрөнгийн 30 хувиас илүү гарахгүй байх ёстой.	Португал
Хоршооны дүрэмд заана.	Ирланд
Ногдол ашиг хуваарилах боломжтой ба ерөнхий хязгаарлалт байхгүй.	Герман

Хоршооны дүрэмд заавал хуваарилах ногдол ашгийг заах, хоршооны бүх гишүүдийн хурал нь сайн дураар хуваарилах ногдол ашгийг заана. Ногдол ашиг ба буцаан олговор гэсэн хоёр ойлголт: Хуулиар заасан нөөцийн санд оруулаагүй илүүдэл хөрөнгийг хоршооны гишүүдэд хоршооны үйл ажиллагаанд оролцох оролцоог нь харгалзан буцаан олгох төлбөрийн хэлбэрээр олгоно.	Испани
--	--------

2.8. Аудит болон бусад хяналт шалгалт

Европын орнуудын хувьд зарим улсад хоршоог аудит зэрэг хяналт шалгалтанд заавал хамруулж байхаар³⁶ заажээ.

Хоршоо нь татварын тусгай дэглэмтэй учраас аудитад хамруулах үндэслэлгүй гэж Бельги зэрэг зарим улсад үзэж байхад Итали, Польш зэрэг зарим улсын хуульд аудит нь зөвхөн хоршооны санхүүгийн байдлыг шалгах зорилготой бус, хоршооны үйл ажиллагааг дэмжиж туслах зорилготой гэж заажээ.

Аудитыг зарим улсад төр захиргааны байгууллага хийдэг бол зарим улсад төрөөс хүлээн зөвшөөрсөн хоршоодын холбоо гүйцэтгэдэг байна. Австри, ХБНГУ зэрэг улсад хоршоо нь хоршоодын холбоонд заавал элсэх үүрэгтэй байдаг. Итали гэх мэт зарим улсад хоршоодын холбоонд заавал элсэх үүрэг байдаггүй бөгөөд ямар нэгэн холбооны гишүүн бус хоршоонд төрөөс аудит хийдэг.

Франц, ХБНГУ, Итали, Испани зэрэг хоршоолол сайн хөгжсөн улсуудад хоршооны аудитыг хоршоодын холбоо гүйцэтгэдэг болохыг дурдах нь зүйтэй. Азийн орнуудын хувьд Япон, Солонгос зэрэг улсуудад засгийн газар хоршооны үйл ажиллагаа, тайлан тооцоо, бүртгэлийн баримтуудыг шалгах эрхтэй байдаг. Тайланд улсад аудит хийх хянан шалгагч нарыг хоршооны бүртгэлийн байгууллага томилох бөгөөд аудитыг тус бүртгэлийн газраас боловсруулсан дүрэм журам, стандартын дагуу гүйцэтгэдэг байна.³⁷ Аудитаас гадна бүртгэлийн байгууллага нь хоршооны үйл ажиллагааны талаар тайлбар шаардах эрхтэй ба мөн хоршооны байцаагч нар хоршоон дээр очиж, ажлын цагаар газар дээр нь шалгалт хийх эрхтэй гэж заажээ.³⁸

Хяналт шалгалтыг хэдэн удаа хийх, заавал хийх ёстой эсэх талаар Японы хуульд захиргааны эрх бүхий байгууллага нь жилд нэг удаа хоршооны үйл ажиллагаа, санхүүг шалгах үүрэгтэй тусгасан байна. Филиппин улсын хуульд хоршоонд санхүүгийн болон нийгмийн гэсэн хоёр төрлийн аудитыг жил бүр хийж байхаар заажээ.³⁹

Хяналт шалгалтыг жил бүр биш юм гэхэд дор хаяж гурван жил тутамд 1 удаа хийж, дараахь зүйлүүдийг шалгавал зохино гэж зөвлөснөөс үзвэл:

- Гишүүдийн хувьцаа;
- Хоршооны үйлчилгээг хэрэглэж буй гишүүдийн тоо хэмжээ;
- Удирдах зөвлөл болон гишүүдийн хурлын зардал, эдгээр зардлыг төсөвт оруулан баталсан эсэх;

³⁶ Cooperative revision, inspection or enquiry.

³⁷ Тайландын хоршооны тухай хууль, 1999, 4-р бүлэг.

³⁸ Мөн хуулийн 3-р бүлэг, 17,18-р зүйл.

³⁹ Филиппин Улсын Хоршооны тухай хууль, 2008/Дугаар 9520, 80-р зүйл.

- Гишүүдийн хурлын баталсан жилийн төлөвлөгөөний биелэлт;
- Хууль, хууль тогтоомжийн бусад актыг мөрдөж буй эсэх.

2.9. Хоршоог татан буулгах

Хоршоог өөрчлөн байгуулах бус⁴⁰, үйл ажиллагааг нь зогсоож, татан буулгах нь чухал шийдвэр учраас бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж, дийлэнх олонхын саналаар шийдвэрлэвэл зохино. Зарим улсын хуульд хоёр удаа дараалж бүх гишүүдийн хурлыг зохион байгуулж, асуудлыг шийдвэрлэхийг заасан байдаг. Хоршоог татан буулгах үндэслэлийг харьцуулбал:

Хүснэгт 9.

	Герман	Солонгос	Тайланд	Филиппин	Энэтхэг	Япон
Хуульд зааснаар бүх гишүүдийн хурлаар дийлэх олонхын саналаар шийдвэрлэх	.	.	.	.	.	.
Гишүүдийн тоо хуульд заасан доод хэмжээнд хүрэхгүй болсон	.					
Хууль, дүрмийг зөрчсөн		.	.	.	.	.
Дампуурсан		.	.			.
Хяналт шалгалт хийсний дараа бүртгэлийн байгууллагаас татан буулгах шийдвэр гаргасан					.	
Хоршооны үүсгэн байгуулсан хугацаа дууссан	.			.		.
• Хуурамчаар бүртгүүлсэн, • Хууль бус зорилгоор үйл ажиллагаа явуулах				.		
Хууль бус үйл ажиллагаа эрхлэх						.
Эрх мэдэл бүхий сайдыг тушаалаар татан буулгах		.				

Татан буулгасан хоршооны үлдсэн эд хөрөнгийг гишүүдэд хуваарилахыг зарим улсад хуулиар зөвшөөрсөн байхад зарим улсад хоршооны дүрмээр зохицуулна гэжээ.

Хүснэгт 10.

Юуны түрүүнд үүрэг гүйцэтгүүлэгчийн нэхэмжлэлийг барагдуулж, дараа нь гишүүдэд хувийг нь буцааж олгосны эцэст үлдсэн хөрөнгийг хуваарилна	Австри
---	--------

⁴⁰ Хоршоог нийлэх, хуваах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулах боломж байдаг.

Үлдсэн эд хөрөнгийг гишүүдэд хуваарилахыг хуулиар зөвшөөрсөн	Бельги, Герман, Тайланд, Филиппин, Энэтхэг
Зарчмын хувьд хоршооны дүрмээр зохицуулна	Герман, Их Британи
Өр төлбөрийг барагдуулж, гишүүдэд нийлүүлсэн хувь хөрөнгийг нь эргүүлж олгосны эцэст үлдсэн хөрөнгийг бусад хоршоо, хоршоодын холбоонд хандивлах, эсвэл нийтийн болон мэргэжлийн эрх ашгийн үүднээс явуулах үйл ажиллагааг санхүүжүүлэх	Франц
Үлдсэн эд хөрөнгийг хоршоодын холбооноос заасан өөр нэг хоршоонд хандивлана	Португал

2.10. Хоршооны татварын харилцаа

Хоршооны татварын харилцааг ямар хууль тогтоомжоор зохицуулдаг, хоршооны гишүүд нь татвараа хэрхэн төлдөг талаар ОХУ-ын холбогдох хууль тогтоомжоос үзэхэд бүх төрлийн хоршооны татварын зарчим нь ерөнхийдөө адилхан боловч зорилгоороо ялгаатай байна. Гишүүн татвараас гадна нэмэлт татвар буюу хоршоонд учирсан хохирлыг арилгах зорилгоор төлдөг нөхөн төлбөр хэлбэрийн татвар ч бас байдаг байна.

Үйлдвэрлэлийн хоршооны тухай хууль 1996.04.10, сүүлийн нэмэлт өөрчлөлт 2011.11.30-нд хийгдсэн, Үйлдвэрийн болон бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэх, дахин боловсруулах, хангах, худалдаа, барилга байгууламж, үйлчилгээ, ашигт малтмал олборлох гэх мэт хуулиар хориглоогүй үйл ажиллагаа эрхлэх хоршоог байгуулах, үйл ажиллагаа явуулах, дуусгавар болгохтой холбоотой харилцааг зохицуулсан	Хоршооны хөрөнгө нь гишүүдийн оруулсан хувиас бүрдэнэ. Гишүүдийн оруулах хувийн хэмжээ, оруулах журмыг хоршооны Дүрмээр тогтооно.
Орон сууцны хуримтлалын хоршооны тухай хууль 2004.12.22, сүүлийн өөрчлөлт 2008.07.23-нд хийгдсэн, Энэ хоршоо нь гишүүдийн татварыг нэгтгэх замаар гишүүдийнхээ орон сууцны хэрэгцээг хангах зорилготой хэрэглэгчийн хоршоо байна.	Элсэлтийн татвар, гишүүнчлэлийн татвар, нэмэлт татвар төлнө, дүрмээр зохицуулагдана
Зээлийн хоршооны тухай хууль 2009.07.07, сүүлийн өөрчлөлт 2011.11.21 хийгдсэн, Гишүүдийнхээ санхүүгийн хэрэгцээг хангах зорилгоор нутаг дэвсгэрийн, мэргэжлийн болон бусад зарчмаар гишүүнчлэлийн үндсэн дээр иргэд хуулийн этгээдийн нэгдэл байна	Элсэлтийн татвар, гишүүнчлэлийн татвар, нэмэлт татвар төлнө, дүрмээр зохицуулагдана
Хөдөө аж ахуйн хоршооллын тухай хууль 1995.11.15, сүүлийн өөрчлөлт 2011.12.30 хийгдсэн. Хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид хувиараа аж ахуй эрхлэгчид сайн дурын гишүүнчлэлийн үндсэн дээр өөрийн хэрэгцээгээ хангах зорилгоор эд хөрөнгөө нэгтгэн хамтран үйлдвэрлэлийн болон аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг байгууллага байна.	Заавал болон нэмэлт татвар гэж зохицуулсан. Заавал татварыг төлснөөр хоршооны үйл ажиллагаанд оролцох, санал өгөх, хөнгөлөлт эдлэх зэрэг эрхийг эдэлнэ, харин нэмэлт татварыг төлснөөр ногдол ашиг авах эрх эдэлнэ.

* * *

Хавсралт 1.

Нийгмийн хөгжилд хоршооллын гүйцэтгэх үүрэг

Ерөнхий Ассамблей

Хоршооллын хөгжлийг дэмжих орчин бий болгоход чиглэсэн НҮБ -ын зааварчлагыг



боловсруулах шаардлага, боломжийг Хоршооллыг хөгжүүлж, урагшлуулах асуудлыг эрхэлсэн Хороотой хамтран судлахыг Ерөнхий нарийн бичгийн даргаас хүссэн заалт бүхий 1992 оны 12 дугаар сарын 16 -ны 47/90, 1994 оны 12 дугаар сарын 23-ны 49/155, 1996 оны 12 дугаар сарын 12-ны 51/58 тоот тогтоолдоо тус, тус тэмдэглэсэн,

Нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ чиг хандлага бол хоршооллын гүйцэтгэх үүрэг, статусын тухай Ерөнхий нарийн бичгийн даргын илтгэл, түүний хавсралт бүхий хоршооллын хөгжлийг дэмжих орчин бий болгоход чиглэсэн зааварчлагын төслийг хүлээн авч,

Хоршооллын төрөл бүрийн хэлбэр ньзалуучууд, ахмад настан, тахир дутуу хүмүүс, эмэгтэйчүүд зэрэг нийгмийн бүхий л бүлгийг хөгжлийн үйл явцад бүрэн дүүрэн оролцуулах нийгэм, эдийн засгийн чухал хүчин зүйл мөн хийгээд, нийгмийн наад захын үйлчилгээг хүн ардад хүртээмжтэй болгох үр ашигтай, зардал багатай механизм болохыг хүлээн зөвшөөрч,

Нийгмийн хөгжлийн асуудлаархи дээд хэмжээний уулзалт, эмэгтэйчүүдийн дэлхийн IV бага хурал, Хүн амын суурьшлын асуудлаархи НҮБ-ын бага хурал /Хабитат II/, Дэлхийн хүнсний дээд хэмжээний уулзалт болон тэдгээрийн таван жилийн хэрэгжилтийг хэлэлцэх хурал, шийдвэрийн мөрөөр хэрэгжүүлэх үйл явцад бүх төрлийн хоршоодын оруулах чухал хувь нэмэр, нөөц бололцоог мөн хүлээн зөвшөөрч,

1. Нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ чиг хандлага ба хоршооллын гүйцэтгэх үүрэг, статусын тухай Ерөнхий нарийн бичгийн даргын илтгэлийг талархан тэмдэглэж байна;
2. Хоршооллын хөгжлийг дэмжих орчин бий болгоход чиглэсэн зааварчлагын төсөл боловсруулсныг талархан хүлээн авч;
3. Зааварчлагын төслийн хувьд Засгийн газрудын саналыг авч, шаардлагатай бол шинэчилсэн хувилбар боловсруулж, батлуулахыг Ерөнхий нарийн бичгийн даргад үүрэг болгож;
4. Нийгмийн хөгжлийн асуудлаархи дээд хэмжээний уулзалт, эмэгтэйчүүдийн дэлхийн IV бага хурал, Хүн амын суурьшлын асуудлаархи НҮБ-ын бага хурал /Хабитат II/, Дэлхийн хүнсний дээд хэмжээний уулзалт болон тэдгээрийн таван жилийн хэрэгжилтийг хэлэлцэх хурал, шийдвэрийн мөрөөр хэрэгжүүлэх үйл явцад бүх юрлийн хоршоодын гүйцэтгэх үүрэг, оруулах хувь нэмрийг-зохих осоор бодолцон олон улсын болон үндэсний хоршооллын байгууллагуудтай хамтран ажиллахыг Засгийн газрууд, олон улсын холбогдох байгууллага, төрөлжсөн байгууллагуудад уриалж байна. Үүнд:
 - а/ Нийгмийн хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, ялангуяа ядуурлыг арилгах, үр бүтээлтэй ажлын байраар хангах, нийгмийн интегрцлалыг бэхжүүлэхэд хоршооллын хувь нэмэр, нөөц бололцоог бүрэн дүүрэн хөгжүүлж ашиглах,
 - б/ Хоршоолол байгуулан хөгжүүлэхийг хөхиүлэн дэмжих, тухайлбал сайн дурын үндсэн дээр хоршоолол байгуулан хөгжүүлэх боломжийг нийгмийн эмзэг бүлгийнхэн буюу ядуу, орлого багатай хүмүүст олгох чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэх,
 - в/ Хоршооллын хөгжлийг дэмжих таатай орчин бий болгох чиглэлэр холбогдох арга хэмжээ авах, тухайлбал Засгийн газар болон хоршооллын хөдөлгөөний хооронд үр өгөөжтэй түншлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх,
5. 1992 оны 12 дугаар сарын 16 -ны өдрийн 47/90 дугаар тогтоолд Ерөнхий Ассамблейгаас жил бүрийн 7 дугаар сарын эхний бямба гаригийг Олон улсын хоршооллын өдөр болгон тунхагласны дагуу үргэлжлүүлэн тэмдэглэж байхыг Засгийн газрууд, олон улсын холбогдох байгууллага, төрөлжсөн байгууллага,

орон нутгийн, үндэсний болон олон улсын хоршооллын байгууллагуудад уриалж байна.

6. Хоршооллын хөгжлийг таатай орчин бий болгох чиглэлээр Засгийн газруудын тавьж буй хүч чармайлт, тухайлбал үндэсний, дэд бүтцийн болон бүс нутгийн хэмжээнд сургалт, семинар зохион байгуулахад нь НҮБ-ын холбогдох байгууллага, олон улсы бусад байгууллагатай хамтран туслалцаа дэмжлэг үзүүлэхийг Ерөнхий нарийн бичгийн даргад үүрэг болгож байна.
7. Энэхүү тогтоолын хэрэгжилтийн талаархи илтгэлийг гишүүн орнууд болон НҮБ, олон улсын бусад байгууллагатай зөвлөлдсөний үндсэн дээр бэлтгэж, Ерөнхий Ассамблейн 56 дугаар чуулганд Эдийн засаг, нийгмийн зөвлөлөөр дамжуулан оруулахыг Ерөнхий нарийн бичгийн даргад мөн үүрэг болгож байна.



UIH.MN
СУДАЛГААНЫ САН